



**“БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ,
ШИЙДЭЛ, АРГА ЗАМ”**
сэдэвт эрдэм шинжилгээний үндэсний 11 дүгээр
хурлын хураангуйн эмхтгэл

Улаанбаатар
2025

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН.



Ажлын хэсгийн ахлагч:	Т.Ганбаатар	Монгол улсын боловсролын их сургуулийн Математик, байгалийн ухааны сургуулийн захирал
Нарийн бичгийн дарга:	А.Амарзаяа Э.Азжаргал	МУИС-ийн ШУС-ийн багш, дэд профессор МУБИС-ийн МБУС-ийн хөтөлбөрийн албаны дарга, дэд профессор
	Я.Мөнхсайхан С.Гэндэнжамц Ц.Лувсандорж	МУБИС-ийн МБУС-ийн багш БҮТ-ийн Даалгаврын сангийн хэлтсийн дарга МУБИС-ийн МБУС-ийн Дидактикийн тэнхимийн эрхлэгч
Гишүүд:	Д.Цэдэвсүрэн	МУБИС-ийн профессор Сургалт, цахим шилжилтийн хэлтсийн дарга
	Л.Мөнхтуяа	МУБИС-ийн Тамгын газрын дарга, дэд профессор
	О.Алтангоо	МУБИС-ийн дэд профессор
	Д.Цолмонтуяа	МУБИС-ийн БТС-ийн багш, дэд профессор
	А.Амгалан	МУБИС-ийн БТС-ийн багш
	Д.Энхцэцэг	МУБИС-ийн БС-ийн багш, дэд профессор
	Я.Мөнхсайхан	МУБИС-ийн МБУС-ийн багш
	Г.Өлзийсайхан	МУБИС-ийн БоСС-ийн багш
	Б.Оюун-Эрдэнэ	МУБИС-ийн МБУС-ийн багш
	У.Алимаа	МУБИС-ийн МБУС-ийн багш
	А.Амгалан	МУБИС-ийн МБУС-ийн багш
	Т.Ганзориг	МУБИС-ийн МБУС-ийн багш
	Ц.Амартайван	МУИС-ийн Ахисан түвшний сургуулийн захирал, профессор
	Ч.Нямгэрэл	МУИС-ийн ШУС-ийн багш, дэд профессор
	Д.Түмэнбаяр	МУИС-ийн ШУС-ийн багш, дэд профессор
	Ц.Навчаа	МУИС-ийн ШУС-ийн дэд профессор
	Б.Алтангэрэл	МУИС-ийн ШУС-ийн дэд профессор
	Б.Болдсүрэн	МУИС-ийн ШУС-ийн багш
	Д.Золжаргал	МУИС-ийн ШУС-ийн дэд профессор
	С.Соёлжин	МУИС-ийн ШУС-ийн дэд профессор
	Б.Буяндэлгэр	БСҮХ-ийн секторын эрхлэгч
	Г.Бүрэнжаргал	БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
	Р.Нямцэрэн	БСҮХ-ийн секторын эрхлэгч
	Б.Лхамцэрэн	БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
	Б.Лхагвабаяр	БЕГ-ын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга
	Д.Сумъяа	БЕГ-ын Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Д.Отгонтуяа	БЕГ-ын Математикийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан, арга зүйч, мэргэжилтэн
	Д.Энхжаргал	БҮТ-ийн Элсэлтийн ерөнхий шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Отгон-Эрдэнэ	БҮТ-ийн Даалгаврын сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	А.Даваадулам	БҮТ-ийн Даалгаврын сангийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Гэндэнжамц	БҮТ-ийн Даалгаврын сангийн хэлтсийн дарга

“БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ АРГА ЗАМ-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2024 оны 5 дугаар сарын 16 **Чиглүүлэгч:** проф. Ц.Лувсандорж, МУБИС
Хаана: МУБИС, I-312 тоот **дэд проф. А.Амарзаяа, МУИС**

НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хугацаа	Үйл ажиллагаа
08 ⁴⁰ -09 ¹⁰	Бүртгэл
09 ¹⁰ -09 ⁴⁰	Хурлын нээлт: - Урлагийн мэндчилгээ - Мэндчилгээ дэвшүүлж үг хэлэх (БШУЯ, БЕГ, МУБИС, МУИС, БСҮХ, БҮТ)

УРИГДСАН БОЛОН ҮНДСЭН ИЛТГЭЛ

Илтгэлийн сэдэв	Илтгэгч
Уригдсан илтгэл 1: Боловсролын квант хандлага	Б.Жадамба, Академич МУБИС
Уригдсан илтгэл 2: Боловсрол дахь хиймэл оюуны чиг хандлага	Д.Золжаргал, дэд профессор МУИС, ШУС
Асуулт, хариулт	
Үндсэн илтгэл 1: Эмоцийн конструктивизм дижиталчиллын үеийн боловсролын гүн ухаан болох нь	Ц.Лувсандорж профессор, МУБИС, МБУС,
Цайны завсарлага	
Үндсэн илтгэл 2: Бага боловсролын туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгарч буй асуудлыг СВAM загвараар илрүүлсэн үр дүн	Ж.Дэнсмаа, Х.Энхжаргал, М.Итгэл БСҮХ
Үндсэн илтгэл 3: Боловсролын чанарын үнэлгээ ба баталгаажуулалт	С.Гэндэнжамц, Боловсролын Үнэлгээний Төв
Үндсэн илтгэл 4: Талбарын санаачилгаас албан боловсролд Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын нөхцөл байдлын судалгаа	Б.Болдсүрэн, МУИС, ШУС
Үндсэн илтгэл 5: Боловсролын бодлогын хэрэгжилт, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц, анхаарах зүйл	Б.Лхагвабаяр, Боловсролын Ерөнхий Газар

Ерөнхий хөтөлбөр

№	Үйл ажиллагаа	Хугацаа
2025 оны 5 дугаар сарын 16, 09.00-18.00		
5	Үдийн завсарлага	13.00-13.40
6	Салбар хуралдаанууд	13.40-18.20
2025 оны 5 дугаар сарн 17. 09.00-14.00		
7	Салбар хуралдаанууд	09.00-11.00
8	Цайны завсарлага	11.00-11.20
9	Салбар хуралдаанууд (оюутан, хэлэлцүүлэг)	11.20-14.00
10	Хаалтын хуралдаан, нэгтгэн дүгнэх, оюутны илтгэлийн шагнал гардуулах	14.00-14.30

Агуулга

ӨМНӨХ ҮГ	7
МЭНДЧИЛГЭЭ	8
МЭНДЧИЛГЭЭ	9
МЭНДЧИЛГЭЭ	10
УРИГДСАН ИЛТГЭЛ	
Боловсролын квант хандлага.....	11
Боловсрол дахь хиймэл оюуны чиг хандлага	11
ҮНДСЭН ИЛТГЭЛҮҮД	
Эмоцийн конструктивизм дижиталчиллын үеийн боловсролын гүн ухаан болох нь.....	12
Талбарын санаачилгаас албан боловсролд: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын нөхцөл байдлын судалгаа	12
Бага боловсролын туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгарч буй асуудлыг СВAM загвараар илрүүлсэн үр дүн	13
Боловсролын чанарын үнэлгээ ба баталгаажуулалт	14
АМАН ИЛТГЭЛҮҮД	
Суралцагчийн суралцахуйн хэв шинжийн ялгаатай байдлыг харгалзсан хичээл боловсруулж туршсан үр дүн	15
Англи хэлний холимог түвшинт бүлэгт багшлахад тулгардаг бэрхшээл, түүнийг даван туулах арга зам.....	15
Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын үр ашгийг үнэлэх нь	16
Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгт суралцахуйн зарим асуудалд.....	16
Хорих ангид ял эдэлж буй насанд хүрэгчдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтын үр дүнтэй аргыг судалсан нь.....	17
Esp32 хавтанд суурилсан бүтээлийг блүтүүт андройд аппликэйшнээр дэмжих боломж ...	17
Өглөөний цай уух дадал зуршил, оюутнуудын хичээлийн идэвхи оролцоонд үзүүлэх нөлөөллийг судлах нь.....	18
Технологийн дэвшил дэх багшлахуй ба суралцахуй (Хэрлэн нэгдүгээр сургуулийн түүх нийгмийн ухааны хичээлийн жишээн дээр)	18
Их сургуулийн орчин дахь хиймэл оюун (AI)-ы хэрэглээг зохицуулах бодлого (МУИС-ийн оюутнуудын хиймэл оюун ухааны хэрэглээний жишээн дээр)	18
Мэргэжлийн болон Техникийн салбарын түншлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа (Барилгын салбарын жишээн дээр).....	19
Төрийн багшийн боловсролд анхаарах асуудлууд.....	19
Хэлний цогц ур чадварыг интеграци хичээлээр хөгжүүлэх нь	20
“Тогтвортой хөгжлийн үзэл санааг”-г нийгэм судлал хичээлээр дамжуулан бусад хичээлтэй интеграцилах боломж (8-р ангийн төсөлт ажил болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны жишээн дээр)	20
ЕБС-иудын ба багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд хийсэн шинжилгээ.....	21
Хиймэл оюун ухааны хэрэглээ ба боловсролын тогтвортой хөгжил.....	21

Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг хиймэл оюун ашиглан үнэлэх боломж ...	21
Суралцагчийн онцлогт тулгуурлан боловсруулсан сургалтын аргын нэгэн хувилбарыг туршсан байдал	22
Бакалаврын судалгааны ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг машин сургалтын бүлэглэх арга ашиглан шинжлэх нь	22
Боловсролын ноксологи ба эрсдэлийн менежмент	23
Завхан аймгийн ЕБС-иудын багшийн дутагдал, цаашдын хандлага, бууруулах арга зам...	23
Гүн сургалтын seq2seq загварт тулгуурлаж Англи-Монгол нейроны машин орчуулгыг сайжруулах нь.....	24
“Хөгжлийн бэрхшээлийг ойлгоё” хичээлийн зарим үр дүнгээс (4 дүгээр ангийн жишээн дээр)	24
Холболтын дүрэм ашиглан хичээлүүдийн дүнгийн хамаарлыг шинжилж, хөтөлбөрийг сайжруулах боломжийг судлах нь.....	25
Ерөнхий боловсролын сургалтад ирээдүйгээс эргэн төлөвлөх (backcasting) аргыг хэрэглэх нь: тохиолдлын судалгаа	25
Оюутнуудын бие хүний их таван шинжийг судалсан үр дүн	26
Нийгэм сэтгэл хөдлөлийн чадамжийг ээлжит хичээлээр төлөвшүүлэх нь (6-р ангийн англи хэл, эрүүл мэндийн интеграц хичээлийн жишээн дээр).....	26
Хөгжмийн мэргэжлийн суралцагчдад тулгамдаж буй зарим асуудал (Хийл хөгжмийн жишээн дээр).....	27
Физик, математикийн агуулгыг интеграцчилан заасан хичээл нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх эсэхийг судалсан нь	27
Шууд сургалтын загвар ашиглан геогебра ангиар туршсан танхимын сургалтын үйл ажиллагааны үр дүн (V ангийн тэнхлэгийн тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлт хичээлүүдийн жишээн дээр).....	27
Монголын химийн сургалтын цөм хөтөлбөр болон Кембрижийн химийн хөтөлбөрийн суралцахуйн зорилтын агуулга, бүтцийн харьцуулсан судалгаа.....	28
Газар зүйн мэдээллийн системийн өгөгдөлд суурилан боловсролын хүртээмжийг сайжруулах боломж	29
Шинэ эгэл арга зүй: Монгол хүний хөгжлийг дэмжих цогц арга ухаан	29
ЕБС-ийн багш нарын ажил-амьдралын тэнцвэрийн судалгаа.....	30
Үйл ажиллагааны интеграцид суурилсан бие даалтаар ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгосон туршлага, үр дүн (Англи хэл, нийгэм судлалын хичээлийн жишээн дээр)	30
ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний үр дүнгээс	31
Оюутны суралцах төлөв ба хичээл сонголтын хамаарал	32

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ИЛТГЭЛҮҮД

Дидактик төвийн онол: үндэс, зарчим, хэрэглээ, ач холбогдол.....	33
Integrating Pop Culture into English Language Teaching: Enhancing Engagement and Learning at the National University of Mongolia	33
Оюутны стресс, бэрхшээлийг тэсвэрлэх, даван туулах, ангижрах чадварыг үнэлэх нь.....	33
Дэлхий судлалын дээд боловсрол ба төлөв	34

ОЮУТАН СУДЛААЧИЙН ИЛТГЭЛҮҮД

Мэргэжил сонголтод нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ.....	35
Тэгш хамруулан сургах боловсролд сургуулийн удирдлагын оролцоо (ЕБС-ийн жишээн дээр)	35
Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах буй 4-5 настай аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн нийгэмшихүйн чадварыг хөгжүүлэх нь	36
Санхүүгийн мэргэжилтэнд өгөгдлийн шинжилгээний мэдлэг, чадварыг эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагыг өгөгдөл олборлолтын аргаар тодорхойлох нь	36
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаа.....	37
Гэрийн даалгаврын талаарх тулгамдсан асуудал, шийдэл.....	37
Сурагчдын химийн бодлого бодох чадварыг сайжруулах арга зүйн нэгэн хувилбар	38
Судалгааны ажлыг гүйцэтгэх мэдлэг чадварыг баримт бичгийн шинжилгээнд тулгуурлан тодорхойлох нь (МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн оюутнуудын судалгааны ажлын жишээн дээр)	38
Тэмдэглэл	40

ӨМНӨХ ҮГ

Эрхэм хүндэт багш, судлаач та бүхэндээ үүнийг унших өдрийн мэнд хүргэе.

2014 онд “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний анхдугаар хурал санаачлан, жил бүр уламжлал болгон зохион байгуулж эхэлснээс хойш хэдийнээ 11 дэх удаагаа болжээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын онцлог нь боловсролын бүх түвшний сургалт, хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээ, багшийн хөгжилд тулгамдаж буй асуудал, боловсролын бодлого, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар судалсан, судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголцолд хүрэх, бүх түвшний хамтын ажиллагааны уялдаа холбоо, хамтын судалгааг эрчимжүүлэх боломж олгодогт оршдог.

Энэ удаагийн хуралд сургуулийн өмнөх, бага боловсрол, ерөнхий боловсролын сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн оюутан, багш судлаачдын нийт 100 орчим өгүүлэл ирснээс экспертийн уншилтаас шалгуур хангасан 60 орчим өгүүлийг хэлэлцүүлэхээр сонгосон байна. Мөн жил бүр уламжлал болгон хамтран зохион байгуулагч 5 байгууллага болох МУБИС, МУИС, Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, Боловсролын Үнэлгээний Төв, Боловсролын Ерөнхий газраас тухайн цаг үеийн боловсролын бодлого, асуудал, шийдэл, хийж буй ажлын үр дүн, чиг хандлагыг илэрхийлсэн уригдсан болон үндсэн илтгэлүүд тавигддаг. Энэ удаагийн хуралд тодорхой асуудлын шийдэл, чиг хандлагыг хэлэлцүүлэх, илтгэгчээс гадна хуралд оролцогч, сонсогчид санал бодлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор хэлэлцүүлэгт илтгэлийн хэлбэрийг нэмснээрээ онцлог болж байна.

Боловсролын салбарт гарч буй судалгааны шинэ чиг хандлага, шинэ технологи, арга зүй, тулгарч буй асуудал, бэрхшээл, түүнийг даван гарах боломж, шийдлийн талаар хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулахаар энэхүү хурлыг сонгон оролцож буй судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, багш, оюутан та бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлье.

Энэхүү хурлын хүрээнд хэлэлцүүлсэн илтгэл, өгүүллээс, боловсролын тулгамдсан асуудлыг шийдэх олон санаа, бодит үр дүнгүүд гарна гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ эрдэм, бүтээлийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Зохион байгуулагч:
МУБИС-ийн Математик, Байгалийн Ухааны Сургууль
МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургууль.

МЭНДЧИЛГЭЭ



БЕГ, БСҮХ, БҮТ, МУИС, МУБИС хамтран боловсролын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, гарц шийдлийг хамтдаа эрэлхийлсэн эрдэм шинжилгээний хурлыг «Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам» сэдвийн хүрээнд зохион байгуулаад өдгөө арван нэг дэх жилтэйгээ золгож байна.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь Монгол Улсын боловсролын бодлого, хөгжлийн стратегийн төлөвлөлт ба хэрэгжилт, монгол хүүхдийн хөгжил, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, багшлахуй ба суралцахуйд тулгамдаж

буй асуудлуудыг хэлэлцэж, шийдэл гаргах судлаачдын нээлттэй талбар бий болгон, шийдэх арга замыг түгээдэг уг эрдэм шинжилгээний хуралд өндөр ач холбогдол өгч, шийдлүүдийг хэрэгжүүлэн ажилласаар ирлээ.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь өдгөө Монголын боловсролыг хөгжүүлэх философийн үндсийг тодорхойлоход үнэ цэнтэй үзэл санааг гаргаж; хүүхэд, залуучууд, багш, сурган хүмүүжүүлэгчид, судлаач, эрдэмтэд, малчин иргэд, бизнес эрхлэгчид болон боловсролын байгууллага, төрийн байгууллага, иргэний нийгэм, нам, эвсэл, хэвлэл мэдээллийн төлөөллийн нэгдэлд тулгуурлан Монгол Улсын боловсролыг тогтвортой хөгжүүлэх “Монголын боловсролын тунхаглал 2024”-ийг гаргаж; “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-ийг боловсруулан Монгол Улсын Засгийн газраар батлуулж, энэхүү үзэл баримтлалын хүрээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлыг өрнүүлж байна.

Энэхүү «Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам» сэдэвт эрдэм шинжилгээний хурлаар боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ тэдгээрт тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон, гарц шийдлийг эрэлхийлсэн судалгааны үр дүнгүүд хэлэлцэгдэж, олон нийтийн хүртээл болох болно.

Хурлыг хамтран зохион байгуулж буй байгууллагууд, хуралд илтгэл хэлэлцүүлж буй судлаачид Та бүгдийн эрдэм судлалын их үйлсэд өндөр амжилт хүсье.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

БСҮХ-ийн захирал Л.ЛХАГВАСҮРЭН

МЭНДЧИЛГЭЭ



Эрдэм шинжилгээний хуралд оролцож буй эрхэм хүндэт та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ жил төрөөс Боловсролыг дэмжих жил болгон зарласан нь "Боловсролын тулгамдсан асуудал шийдэл, арга зам-2025" эрдэм шинжилгээний хуралтай давхацсан жил тохиож байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар энэхүү 10 дахь удаагийн эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж байгаадаа талархалтай байна.

Монголын боловсролын салбарын тулгамдсан асуудлуудыг судалгаанд суурилан, шийдвэрлэх тэдгээрийн гарц гаргалгаа, шийдлийг шинжлэх ухааны онол, арга зүйн үндэслэлтэйгээр гарган хөгжлийн гарцыг тодорхойлоход эрдэмтэн судлаач, багш, оюутан та бүхний оролцоо чухал

юм.

Даяаршлын үеийн боловсролын чиг хандлагад гарч буй өөрчлөлт, шинэчлэл, олон улсын туршлагыг судалж, мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээлч, тогтолцоотой ажил болох судалгааны ажлыг төлөвлөн боловсруулж хамтын ажиллагаандаа уялдаа холбоотой оролцох нь хэрэгжүүлэгчид болон бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад, үр дүнгээ хуваалцах нь хамтын хөдөлмөрийн чухал үзүүлэлт мөн.

Хурлаас гарсан оновчтой шийдэл, санал, зөвлөмж бүрийг бүх шатны боловсролын бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд тусган ажиллахад Боловсролын ерөнхий газар голлох үүрэгтэй оролцох болно.

Хурлыг хамтран зохион байгуулж буй их дээд сургуулиуд, боловсролын салбарын мэргэжлийн байгууллагынхандаа болон хуралд оролцогч гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, багш нартаа цаашдын эрдэм судлалын үйлсэд нь өндөр амжилт хүсье.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ, БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Т.НЯМ-ОЧИР

МЭНДЧИЛГЭЭ



Боловсролын үнэлгээний төв нь 11 жилийн өмнө МУБИС болон БМДИ хамтран «Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам» хурлыг санаачлан эхлүүлж байсан. Хурлын хамтын ажиллагааны хүрээнд МУИС, МУБИС болон БСҮХ, БЕГ-тай хамтран судалгааны төслүүдийг хэрэгжүүлж, шинжилгээний үр дүнд гарсан илтгэлийг хурлын хүрээнд хэлэлцэж, улам бүр өргөжсөөр байна. Хурлын хүрээнд боловсролын судалгаанд өгөгдлийн шинжилгээнд тулгуурлан гаргасан үр дүн болон боловсролын бодлого шийдвэр, энэ чиглэлийн олон салбарт нөлөөлж, тодорхой үр нөлөө үзүүлсээр ирсэн байна. Үүний жишээ нь хувь хүн, албан байгууллага, төрийн бус

байгууллага боловсролд анхаарлаа хандуулж элсэлтийн шалгалтад сурагч нь өндөр оноо авсан тохиолдолд багшийг урамшуулдаг систем аймаг нийслэлийн сургуулиудад өссөн явдал юм.

Манай байгууллага боловсролын салбарт олон төрлийн судалгаа, үйлчилгээ явуулж байгаа бөгөөд судалгааны үр дүнгээр “Гүйцэтгэлийн үнэлгээ”-ний дундаж, сурлагын амжилт жил бүр өсөж байгаад таатай байна.

Монгол улсын боловсролын хөгжлийн бодлого төлөвлөлт, ирэх зууны иргэдийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, боловсролын үнэлгээнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, арга замыг түгээдэг уг эрдэм шинжилгээний хуралд БҮТ өндөр ач холбогдол өгч, шийдэл, арга замыг хэрэгжүүлэн ажилласаар ирсэн. Дэлхийн боловсролын чиг хандлагад гарч буй шинэчлэл, олон улсын боловсролын хөгжлийн туршлагыг судалж, тогтолцоондоо нутагшуулах, харилцан хүлээн зөвшөөрөх үйл явц дэлхийн өнцөг булан бүрт өрнөж байна.

Сургууль, багш, суралцагчийн тасралтгүй хөгжлийг дэмжих явцыг бодлогоор хөтлөх эрэлт хэрэгцээ их байна. Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар олон арван илтгэлийг хэлэлцэж, боловсролын хөгжилд хувь нэмэр болох шилдэг аргачлал, шинэлэг санаа, үзэл бодлыг нийтэд хамтран түгээж буй та бүхэндээ талархаж байна.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ГАНТУЯА

УРИГДСАН ИЛТГЭЛ

Боловсролын квант хандлага

Академич Б.Жадамба (МУБИС)

Хураангуй: Өнгөрсөн зууны сүүлээр хөгжиж эхэлсэн квант хандлагын дагуу өнөөдөр шинжлэх ухааны зарим, тухайлбал, хими, биологи, сэтгэл судлал, мэдээлэл харилцааны технологийн...гэх мэт салбар классик хүрээнээсээ гарч хөгжлийн квант шатандаа шилжин хөгжиж байна. Гэтэл боловсролын салбар бусдаас хоцорч классик хүрээндээ эргэлдэж хүний хөгжлийг нэг л биш болгож, дэлхий нийт болон улс орнууд жам ёсны дэвшил алдагдагдахад хүрч байна. Үүний учир шалтгаан нь бидний квант хандлагыг төдийлэн сайн ойлгож ухаарахгүйд байна гэж үзэн мөхөс миний бие боловсролын квант хандлагыг тодруулан томъёолохыг зорисон болно. Энэхүү зорилгод хүрэх ажил квант ухааныг деконструктив аргаар задлан шинжилж, нэгтгэн дүгнэж квант хандлагыг оновчлохоос эхэлсэн. Оновчилсон квант хандлагатаа түшиглэн боловсролын квант хандлага нь "боловсролын квант онол – боловсролын квант шинжилгээ – боловсролын квант сэтгэлгээ" гэсэн "арга – арга билэг – билэг" лугаа гурвал бүтэц бүхий болохыг илрүүллээ. Боловсролын квант хандлагын арга тал болох боловсролын квант онол нь боловсролыг хүн төрөлхтний бүтээсэн "нэгэн феномен" болох "нэгэн боловсрол". Нэгэн боловсрол нь "нэг боловсрол* – нэг боловсрол – боловсрол нэг*" гурвал бүтэцтэй гэж үзэхүй. Боловсролын квант сэтгэлгээ нь боловсролыг арга талаасаа бол "нэг боловсрол*". Арга билэг талаасаа бол "нэг боловсрол". Билэг талаасаа бол "боловсрол нэг*" гэж тус тус төсөөлөхүй. Боловсролын квант шинжилгээ нь арга, арга билэг, билэг гурван тал тус бүрийг "үйл" -ээр нь л шинжих хэрэгтэй гэсэн санаа байна. Бий болсон үр дүнгийн тохироц, найдвартай байдлыг өнөөгийн боловсролд шинээр бий болсон санаануудтай гурвалжийн аргаар харьцуулсан шинжилснийхээ үндсэн дээр боловсролын квант хандлага нь үнэхээр классик боловсролыг шинэ шатанд хөгжүүлэх арга хэрэгсэл мөн байна гэсэн дүгнэлтэд хүрлээ

Түлхүүр үгс: квант ухаан, квант хандлага, боловсролын квант онол, боловсролын квант сэтгэлгээ, боловсролын квант шинжилгээ

Боловсрол дахь хиймэл оюуны чиг хандлага

Д.Золжаргал, дэд профессор
МУИС, ШУС

Хураангуй: 2022 оны сүүлээс олны хүртээл болсон ChatGPT хиймэл оюуны хэрэглээ эрчимжиж хиймэл оюун болон түүний хэрэглээ нийгмийн бүхий л салбарт чухалчлан авч үзэх болжээ. Хиймэл оюун нь боловсролын салбарт олон үүрэг гүйцэтгэж, боловсролын орчин, сургалт, багшлахуй болон суралцахуйд өөрчлөлт хувьсалыг авчирч байгааг олон судалгаанаас харж болох юм. Энэхүү илтгэл нь хиймэл оюуны боловсролд хийж буй өөрчлөлт, шинэчлэлт, боломж, бэрхшээл болон цаашдын чиг хандлагыг олон улсын судалгааны өгүүлүүд дээр анализ хийн, нэгтгэн дүгнэх гэж оролдсон болно. Судалгаанаас харахад хиймэл оюуны нөлөө боловсролын салбарт ихээхэн өөрчлөлт авчирч байгаа бөгөөд цаашид илүү хувь суралцагчдад тааруулсан, стандарчлал бус, нээлттэй, хүртээмжтэй насан туршийн боловсролыг дэмжих хандлагатай байна.

Түлхүүр үгс: хиймэл оюун, боловсрол, сургалт, суралцахуй, чиг хандлага

ҮНДСЭН ИЛТГЭЛҮҮД

Эмоцийн конструктивизм дижиталчиллын үеийн боловсролын гүн ухаан болох нь

Ц.Лувсандорж¹

¹МУБИС, Математик, Байгалийн Ухааны Сургуль, luvсандорj@msue.edu.mn

Хураангуй: Боловсролын бүхий л хэмжээсийн утга, үйл ажиллагааны бүхий л шинж чанар, агуулга, хэлбэрт хүчтэй, мэдрэгдэхүйцээр нөлөөлж буй дижитал хувьсгал, дижижлал, дижиталчилал, виртуалчилал, дижитал шилжилт, дижитал хувиргалт нь биднийг итгэл үнэмшлээ эргэн харахад хүргэж байна. Боловсролд үндсэндээ дижиталчилагдах, виртуалчилагдах үзэгдлийн субъект болж байна. Боловсролын дижиталчилал, виртуалчилалын чанарт хийсэн асимметр, диконструктив шинжилгээгээр илэрч дэвшигдэж буй нийгмийн сэтгэлгээ формаль логикчилогдох уу, нийтийн боловсрол алгоритмчилагдах уу, боловсролд юу виртуалчлагдахгүй вэ, мөн юу дижитчлагдахгүй вэ, боловсрол хэзээ, ямар нөхцөлд гүйцэт бүрэн дижитчилагдан дижиталчилагдах вэ, бодит багшийг хэзээ виртуал багш бүрэн орлох вэ зэрэг тунамал тулгуур асуултад хариулт өгөх зорилгоор хийсэн гүн ухааны эрэл хайлт, урт хугацааны бодрол, эргэцүүллийн үр болон бүтээгдсэн, эмоцийн мөн чанар, онцлог, түүний боловсрол, хичээл, сургалт, танин мэдэхүйн нөлөөллийг тодотгосон, эмоцийн интеллектгийн онол¹, бүхэлизм², конструктивизм³, диалектик логик⁴, интуитивизм⁵ гэсэн онол сургаалийг эх сурвалж болгосон, эмоцийн конструктивизмын гэж нэрлэж болохуйц боловсролын гүн ухааны нэгэн тогтолцооны үндсэн ойлголт, эпистемологи, аксиологийг энэхүү өгүүллээр танилцуулж үнэний хувийг хэлэлцүүлнэ.

Түлхүүр: эмоцийн конструктивизм

Талбарын санаачилгаас албан боловсролд: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын нөхцөл байдлын судалгаа

Б.Болдсүрэн¹, Л.Зүчи², И.Анужин², А.Ариунзаяа²

¹Монгол улсын их сургууль, Сэтгэл судлалын тэнхим

²СИИ Сургалт Монгол ТББ, Судалгаа, хөгжүүлэлтийн хэлтэс

Хураангуй: Бид энэ судалгааны ажлаараа талбарын оролцогч талуудын санаачилгаас эхлэн үндэсний хөтөлбөр хүрэх бүх шатанд нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын хөгжлийн үйл явцыг судлан зураглахыг зорилгоо. 2022 оны PISA үнэлгээний дүнгээс харахад Монгол сурагчдын сэтгэлзүйн сайн сайхан байдал, академик амжилтын түвшин төдийлөн сайн биш гарсан нь энэхүү сэдэв тулгамдсан асуудал болоод байгааг харуулж байгаа юм. Тиймээс бид “Хамтдаа суралцъя” төсөл, “Зүрх сэтгэлийн боловсрол” хөтөлбөр, СИИ Сургалт, ESEL зэрэг хөтөлбөрийг санаачлагч, хэрэгжүүлэгч институцуудийн тайлангууд, багш, удирдлага, сэтгэл зүйчидтэй хийсэн ярилцлага зэрэг дээр тулгуурлан тулгамдаж буй асуудал, сайн туршлагаудыг илрүүлэн судаллаа. Нийгэм-сэтгэл хөдлөлийн хөтөлбөрүүдийг Орчлон, Оргил, Боролдойн гэр, Логарифм зэрэг хувийн, төрийн өмчийн цэцэрлэг, сургуулиуд хэрхэн хэрэгжүүлж байгааг судалснаар багш нарын хандлага, бэлэн байдал, хөтөлбөр, арга зүйн нийгэм-соёлын тохируулга, институцийн дэмжлэг зэрэгт нийтлэг тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлсон. Эдгээр бэрхшээлүүдийн хажуугаар сурагчдын танин мэдэхүй, зан үйл, сэтгэлзүй, оролцоонд эерэг өөрчлөлт гарч байгаа нь судалгаанаас харагдсан. Боловсролын яамнаас нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг онцлон Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгаж оруулсан нь бодлогын түвшний томоохон ололт хэдий ч урт хугацаандаа хөтөлбөрүүдийн амжилттай байх эсэх нь багшийн мэргэжлийн хөгжил, гэр бүл, олон нийтийн оролцоо, хөтөлбөрийг Монгол

нийгэм соёлын онцлогт хэр зэрэг тохируулсан зэргээс хамаарах юм. Бид судалгааныхаа үр дүнд тулгуурлан багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад нийгэм-сэтгэл хөдлөлийн агуулгыг тусгах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол нийгэм соёлд тохирсон сургалтын сайн туршлагыг хөгжүүлэх, дэлгэрүүлэх зэрэг чиглэлд зөвлөмж санал болгож байна.

Бага боловсролын туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарт тулгарч буй асуудлыг СВAM загвараар илрүүлсэн үр дүн

Ж.Дэнсмаа¹, Х.Энхжаргал², М.Итгэл³

^{1,2}МУБИС-ийн докторант, БСҮХ

³БСҮХ

Хураангуй: Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, тохирцыг шалгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2024-2025 оны хичээлийн жилд бага боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг боловсруулж, тэдгээрийг турших ажлыг зохион байгуулсан. Бага боловсролын 9 судлагдахууны хөтөлбөр, сурах бичгийн эх (сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтэр)-ийг турших явцад багшид тулгарч буй асуудлыг СВAM (санаа зовнисон асуудалд суурилан хэрэгжүүлэх загвар) ашиглан судалсан үр дүнг танилцуулж байна. SoCQ (санаа зовнисон асуудлын үе шатны асуулга) нь багшийг ямар үе шатанд байгааг тодорхойлох үндсэн хэрэгсэл бөгөөд 35 асуултаас бүрдэнэ. Туршилтын сургалтын хөтөлбөрийг "инновац", туршигч багш, сургалтын менежерийг "хэрэглэгч" гэж үзвэл SoCQ нь инновацыг чиглүүлэгч (судлаач, зохион байгуулагч)-д туршилтын явцад багшийн санаа зовнисон асуудлыг илрүүлэх, түүнийг оновчтой аргаар шийдвэрлэх, улмаар сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх боломж олгоно. Судалгаанд нийслэл, аймаг, сумын нийт 26 сургуулийн 1-5 дугаар ангид хичээл зааж буй 101 багш, 24 сургалтын менежер хамрагдсан. SoCQ-ийн үр дүнд багш нар "анхаарал хандуулаагүй" шатанд 63.6, "мэдээллийн" шатанд 75.9, "хувь хүний" шатанд 75.2, "менежментийн" шатанд 54.4, "үр дагаврын" шатанд 31.6, "хамтын ажиллагааны" шатанд 65.4, "дахин тохируулгын" шатанд 57.0 оноотой байна.

Багш нарын сургалтын хөтөлбөрийн талаарх мэдлэг хангалтгүй, түүнийг төдийлөн сонирхдоггүй байна. Багш нарт сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл дутагдалтай бөгөөд тэднийг энэ талаарх сургалт, сурталчилгааны ажилд хамруулах хэрэгтэй. Харин тэд туршилтын сургалтын хөтөлбөрийн сурагчдад үзүүлэх үр нөлөөний талаар бусад үе шаттай харьцуулахад хамгийн бага санаа зовнилтой байна. Багш нарын "хамтын ажиллагааны" шатны оноо өндөр байгаа тул сургалтын хөтөлбөрийг илүү сайн ашиглахад чиглүүлэхийн тулд бусад багш, сургуультай харилцах, хамтран ажиллах боломж олгох замаар тэдний хамтын ажиллагааны асуудлыг багасгах хэрэгтэй. Энэхүү судалгаа нь туршилтын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн санаа зовнисон асуудлыг илрүүлэх, цаашид түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд авах арга хэмжээг тодорхойлоход СВAM загварыг ашиглах нь ач холбогдолтойг харуулж байна..

Түлхүүр үг: Сургалтын хөтөлбөр, туршилт, санаа зовнисон асуудал

Боловсролын чанарын үнэлгээ ба баталгаажуулалт

С.Гэндэнжамц,
Боловсролын Үнэлгээний Төв

Хураангуй: Энэхүү илтгэлдээ боловсролын чанар ба түүний хэмжилтийн загварын талаар дэлхий нийтийн болон үндэсний гэсэн хоёр түвшинд ялган харуулахыг зорилоо. Ингэхдээ боловсролын хэд хэдэн түвшинг бүхэлд нь хамарсан, суралцахуйн оролт, явц, гарцын үе шатуудыг бүрэн багтаасан, цогц чадамж болон чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг холбогдох олон арга хэрэгслээр хэмжиж Борг, Галл нарын боловсруулсан 8 үе шаттай судалгааны асуулга, даалгавар боловсруулах аргазүйг ашиглан үнэлгээний арга хэрэгслийг боловсруулсан. Судалгаанд Улаанбаатар хот болон орон нутгийн 121 сургууль, МБСБ-ын 44 сургалтын байгууллагын 23194 сурагчаас сорил, 19884 сурагчаас асуулга, 159 сургуулийн захирал удирдлага, 686 багш, 1272 эцэг эхчүүдээс мэдээлэл цуглуулж мэдээллээ SPSS 22.0 болон STATA 16.0, Excel програмуудыг ашиглан боловсруулж, Дискриптив анализ, Таамаглал шалгах анализ, Нөлөөллийн шинжилгээ Path analysis, даалгаврын найдвартай байдал, даалгавар хоорондын хамаарлыг шалгаж, үр дүнг тайлбарласан болно.

Түлхүүр үг: Боловсролын чанар, чанарын баталгаажуулалт, боловсролын чанарт нөлөөлөх хүчин зүйлс, үнэлгээний арга хэрэгсэл, даалгаврын найдвартай байдал, даалгаврын тохирц

Боловсролын бодлогын хэрэгжилт: Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц, анхаарах зүйл

Б.Лхагвабаяр,
Боловсролын Ерөнхий Газар

АМАН ИЛТГЭЛҮҮД

Суралцагчийн суралцахуйн хэв шинжийн ялгаатай байдлыг харгалзсан хичээл боловсруулж туршсан үр дүн

Б.Лхагважаргал¹, Б.Энхбилэг², Ч.Нямгэрэл³

¹Нийслэлийн Цэлмэг дижитал сургууль, Lkhagwajargal1103@gmail.com

²Нийслэлийн ерөнхий боловсролын 20-р сургууль, Enkhbileg0313@gmail.com

³МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Химийн тэнхим, Nyamgerel@num.edu.mn

Хураангуй: Суралцагчийн суралцахуйн хэв шинжийн ялгаатай байдлыг харгалзсан хичээл боловсруулан туршиж, суралцагчдын химийн хичээлийн гүйцэтгэлд гарсан өөрчлөлтийг тоон болон чанарын шинжилгээний үр дүнгээр тайлбарлах зорилгоор энэхүү судалгааг хийсэн. Судалгааны ажлаар туршилтын болон хяналтын бүлгийн пост тестийн дундаж оноонд статистикийн хувьд мэдэгдэхүйц ялгаа гарна хэмээн таамаглаж (H_1), Соломоны дөрвөн бүлгийн загварт үндэслэн, боловсруулсан 5 алхамт судалгааны арга зүйгээр туршилт судалгаа явуулсан. Судалгаанд нийслэлийн ерөнхий боловсролын А сургуулийн 9 дүгээр ангийн дөрвөн бүлгийн 168 сурагч 2024-2025 оны хичээлийн жилийн I улиралд хамрагдсан. 9 дүгээр ангид судлах “Атомын бүтэц, үелэх хандлага” сэдвийн найман ээлжит (6х80 минут = 480, 2х40 минут = 80 минут) хичээлийг шууд сургалтын загвар болон интегратив сургалтын загвараар төлөвлөн туршилтын 2 бүлэг (86 сурагч)-т заасан. Претест болон пост тестийн найдвартай байдлыг SPSS программ ашиглан шалгахад дотоод нийцтэй байдлын Cronbach's Alpha коэффициент () гарсан. “Атомын бүтэц, үелэх хандлага” сэдвийн ээлжит хичээлийн төлөвлөлтүүдийг суурь боловсролын 9-р ангийн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтод тулгуурлан интегратив болон шууд сургалтын загвараар боловсруулахдаа харах, сонсох, хүртэх/хүрэлцэх, унших/бичих гэсэн суралцахуйн хэв шинж (хэв маяг)-ийн ялгаатай байдлыг үйл явцын болон бүтээгдэхүүний хувьд харгалзсан. Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалтын үр дүнгээс харахад хичээлд ялгаатай байдлыг харгалзан төлөвлөж, заасан туршилтын бүлгүүдийн сурагчдын гүйцэтгэлийн дундаж оноо хяналтын бүлгүүдийн сурагчдын гүйцэтгэлийн дундаж онооноос дээгүүр үзүүлэлттэй бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаатай байв. Мөн хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар суралцахуйн дан хэв шинж бүхий суралцагчидтай хийсэн бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад ялгаатай байдлыг харгалзсан хичээлийг төлөвлөж заах нь сурагчдын сурлагын гүйцэтгэлд эергээр нөлөөлж, суралцахуйн үр дүнг нэмэгдүүлж буйг харуулж байна.

Түлхүүр үг: Суралцахуйн хэв шинж, харах хэв шинж, сонсох хэв шинж, хүртэх/хүрэлцэх хэв шинж, унших/бичих хэв шинж, Соломоны 4 бүлгийн загвар

Англи хэлний холимог түвшинт бүлэгт багшлахад тулгардаг бэрхшээл, түүнийг даван туулах арга зам

Ж.Төгсөө¹

¹Мандах их сургууль, tugsuu@mandakh.edu.mn

Хураангуй: Суралцахуйн тэгш байдлыг хангах, суралцах чадварыг хөгжүүлэх, эерэг орчноор дэмжих, суралцахуйн амжилтын зөрүүг багасгах, урт хугацааны хэрэгцээнд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх нь бүх түвшний боловсролын байгууллагын зорилго байдаг. Тодорхой нэг судлагдхууныг мэдлэг, чадвар, хандлага, сурах арга барилын ялгаатай түвшинд эзэмшсэн суралцагчдаас бүрдсэн сургалтын орчин нь холимог түвшинт бүлэг юм. Энэхүү судалгаа нь холимог түвшинт бүлэгт багшилж буй англи хэлний багш нарт

тулгардаг бэрхшээл, түүнийг даван туулдаг арга барил, хандлагыг тандах зорилготой ба судалгаанд нийслэл болон орон нутгаас нийт 125 багш хамрагдсан. Багш нарт тулгардаг бэрхшээлийг сурах сэдэл тэмүүлэл, сургалтын үйл явц, материал, зохион байгуулалт гэсэн тус бүр 6 асуулга бүхий 4 үзүүлэлтээр шалгасан. Холимог түвшинт бүлэгт багшлахад тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхдээ багш нар суралцагчийн хэрэгцээ, сэдэл тэмүүлэл, сургалтын зохион байгуулалт, материал, үйл явц, үнэлгээ гэсэн хүчин зүйлийг хэрхэн авч үзэж байгааг тус бүр 6 асуулгатай 6 үзүүлэлтээр, харин сургалтын энэхүү хэлбэрийн зохист байдлыг тэд хэрхэн үзэж байгааг 3 асуулгаар шалгаж өгөгдлийг SPSS 23.0 программ дээр боловсруулсан. Судалгааны үр дүнд холимог түвшинт бүлгийн сургалтын явцад багш нарт нийтлэг хэд хэдэн бэрхшээл тулгардаг хэдий ч шийдэх арга зам нь хязгаарлагдмал, мөн тэд тухайн сургалтын хэлбэрийн давуу талыг хангалтгүй гэж үзэж байгаа нь харагдсан.

Түлхүүр үг: хэлний түвшин, ялгаатай түвшинт бүлэг, гадаад хэлний сургалт, гадаад хэлний багшлахуй

Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын үр ашгийг үнэлэх нь

М.Анармаа¹, М.Болортунгалаг², С.Баярмаа³, Б.Дүүрэнгэрэл⁴, Б.Энххүслэн⁵

¹СЭЗИС

^{2,3,4,5}СЭЗИС-ийн оюутан

Хураангуй: Энэхүү судалгаагаар Монгол Улсын ЕБС-ийн үр ашгийг өгөгдөл дугтуйлах шинжилгээний тогтмол үр өгөөж бүхий, хувьсах үр өгөөж бүхий загваруудаар тус тус үнэлэв. Ингэхдээ ПИСА 2022 өгөгдлийн сангаас онол болон судлагдсан байдалд үндэслэн орцын хувьсагч болох гэр бүл, институцийн хүчин зүйлийг төлөөлж нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн индекс, сурагчийн хүчин зүйлийг төлөөлүүлж гэрийн даалгавар хийх давтамж, сургуулийн хүчин зүйлсийг төлөөлүүлж багш-сурагчийн харьцаа, анги дүүргэлт, материалын хүрэлцээ, мэргэжлийн зэрэгтэй багш нарын эзлэх хувийн үзүүлэлтүүдийг, гарцын хувьсагч болох математик, уншлага, шинжлэх ухааны шалгалтуудын оноог тус тус сонгов. Үр дүнд, судалгаанд хамрагдсан 193 сургуулийн 26-46 нь л үр ашигтай буюу өгөгдсөн орцын түвшинд гарцыг хамгийн их байлгаж чадаж байв. Хотын сургуулиудын үр ашиг хөдөөгийн сургуулиудтай харьцуулахад 7 хувиар илүү байна. Өмчлөлийн төрлийн хувьд, улсын сургуулиудын үр ашиг хувийн сургуулиудтай харьцуулахад 13 хувиар бага байна. Сургуулиуд үр ашигтаа хүрч ажиллахгүй байгаа нь сургуулийн хүчин зүйл болох багш-сурагчийн харьцаа, анги дүүргэлт илүүдэлтэй, суралцагчийн хүчин зүйл болох даалгавар хийх давтамж их, гэр бүл, институцийн хүчин зүйл болох нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн индекс доогуур байгаагаас шалтгаалж байна.

Түлхүүр үг: ПИСА, тогтмол үр өгөөж бүхий загвар, хувьсах үр өгөөж бүхий загвар, орц ба гарц

Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгт суралцахуйн зарим асуудалд

А.Нархажид¹, Б. Сүхболд²

¹МУБИС -ийн докторант, e.em23f501@365.edu.mn

²МУБИС, BoCC, sukbold@msue.edu.mn

Хураангуй: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцаж буй тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах боломж, тэдэнтэй ажилладаг багш, эцэг эхийн сургалтын үйл ажиллагаа дахь интеграци уялдаа холбоог илрүүлэх нь сургалтын чанарыг

дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах орчин нөхцөл хангагдаагүй, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин дутмаг, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих, тэдний ялгаатай байдалд тохирсон сургалтыг хэрэгжүүлэхэд хүүхэд, эцэг эх, багш, цэцэрлэгийн үйл ажиллагааны хоорондын интеграци уялдаа холбоо, хамтын ажиллагаа, энэ асуудлаарх бодлогын хэрэгжилтийг цаашид анхаарч ажиллах хэрэгтэй байна. Судалгааны үр дүнд тулгуурлан бүлгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай арга зүйн зарим зөвлөмжийг боловсруулахад чиглэгдсэн болно.

Хорих ангид ял эдэлж буй насанд хүрэгчдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтын үр дүнтэй аргыг судалсан нь

Г.Түвшинжаргал¹

¹159 дүгээр сургууль, toogii60@gmail.com

Хураангуй: ШШГЕГ-ын ХЯЭА-ны сургалт нийгэм сэтгэлзүйн хэлтэсээс хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд НТБТ-ын төвүүд зарим боловсрол нөхөн эзэмшүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг сургуулиудтай хамтран хорих ял эдэлж байгаа насанд хүрэгчдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж байна. Суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалт явагддаг 6 хорих ангийн 220 хоригдол, 8 НТБТ-н 35 багш, 8 хорих ангийн 74 албан хаагчаас сургалтын үр дүн, хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл, тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлох зорилгоор асуулга судалгааг авч нэгтгэн дүгнэж сургалтын үр дүнтэй арга санал болгох, зайлшгүй шаардлага байгааг илрүүлж санал зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Хоригдол, суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх, сургалтын арга, насанд хүрэгч, насан туршийн боловсрол

Esp32 хавтанд суурилсан бүтээлийг блүтүүт андройд аппликэйшнээр дэмжих боломж

Т.Ганзориг¹

¹МУБИС, Математик, Байгалийн Ухааны Сургууль, ganzorig.t@msue.edu.mn

Хураангуй: Боловсролын системд хүүхдийн авьяас чадвар, бүтээлч байдалд дэмжлэг үзүүлэх олон хэрэглэгдэхүүн байдаг тэдгээрийн нэг нь Arduino, ESP32 микроконтроллер бүхий программчлагддаг хавтангууд юм. Эдгээрийг ашиглан олон төрлийн бүтээл(project) хөгжүүлэх, программчлах боломжтой боловч холбогдох хэрэгсэл, модуль, материал зэргээс хамаарч харилцан адилгүй түвшинд ашиглаж байна. Суралцагч нь бүтээлийг илүү хямд хүртээмжтэй, хялбар аргаар бүтээхдээ бидний хөгжүүлсэн блүтүүт бүхий андройд аппликэйшнийг хэрхэн ашиглаж болох арга зүй туршилт судалгааны үр дүнг энд өгүүлэх болно. Судалгаанд программ хангамжийн ангийн 40 оюутан бүхий 2 групп хамрагдаж тодорхой бүтээл хөгжүүлсэн ба бүтээлд ашигласан блүтүүт андройд аппликэйшн, бүтээлийн тоо, зарцуулсан хугацаа, сайжруулалт зэргийг судалж дүн шинжилгээ хийсэн үр дүнг өгүүлэх болно.

Түлхүүр үг: Блүтүүт андройд аппликэйшн, ESP32 хөгжүүлэлт, Боловсрол, Бүтээлч байдал

Өглөөний цай уух дадал зуршил, оюутнуудын хичээлийн идэвхи оролцоонд үзүүлэх нөлөөллийг судлах нь

Л.Болормаа¹, О.Болорцэцэг², Б.Бүжин³, Б.Мөнхцацрал⁴, С.Танан-Эрдэнэ⁵, Г.Энхжин⁶

¹МУИС, ЗБС,
^{2,3,4,5,6}МУИС-ийн ЗБС

Хураангуй: Энэхүү судалгаа нь өглөөний цай уух дадал зуршил нь оюутнуудын хичээлд идэвхтэй оролцох чадвар, сурлагын амжилтад үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилготой юм. Судалгаанд МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн 1-4-р курсийн 100 оюутан оролцсон ба судалгааны өгөгдлийг анкетын аргаар цуглуулж, SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийсэн. Үр дүнгээс харахад оюутнуудын өглөөний цай уух зуршил нь хичээлийн идэвх оролцоо, анхаарал төвлөрөлтөд эерэг нөлөө үзүүлж байгааг баталсан. Судалгааны ажлын онцлог нь өглөөний цайны хэрэглээ ба сурлагын амжилтын хамаарлыг нутгийн түвшинд судалж цаашид боловсролын салбарт хэрэгжүүлж болох бодлогын зөвлөмж боловсруулахад оршиж байна.

Түлхүүр үг: Өглөөний цайны хэрэглээ, хичээлийн идэвх, хичээлийн оролцоо, анхаарал төвлөрөл, дадал зуршил

Технологийн дэвшил дэх багшлахуй ба суралцахуй (Хэрлэн нэгдүгээр сургуулийн түүх нийгмийн ухааны хичээлийн жишээн дээр)

Г.Цэцэгдулам¹, Г. Оюунгэрэл², А.Алтангэрэл³

^{1,2,3}Хэнтий аймаг, Хэрлэн 1-р сургууль, ganzorigtsetsegdulam@gmail.com

Хураангуй: Боловсролын салбарт хийгдэж буй олон шинэчлэл өөрчлөлтүүд нь сурагчдын хөгжил, төлөвшил нийгэмшихүй насан туршийн суралцахуйг дэмжихэд чиглэгдсэн байдаг. Бидний олгож буй боловсрол нь ямар түвшинд байна, хэр үр дүнтэй байна вэ? гэдгийг гүйцэтгэлд суурилсан үнэлгээнд тулгуурлан тооцдог. Гүйцэтгэлд суурилсан үнэлгээнд ахиц гаргах нь багшийн ажлын нэг хэсэг гэж үзвэл бид юунд дээр анхаарч ажиллах ёстой вэ? гэсэн асуултын хариултыг олохын тулд энэхүү судалгааны ажлаа хийсэн. Нийгмийн хэрэгцээ боловсролын шинэчлэл суралцагчдын онцлог, ялгаатай суралцах хэв шинжид тохирсон ээлжит хичээлийг МХХТ тулгуурлан төлөвлөснөөр асуултынхаа хариуг олох боломжтой.

Түлхүүр үг: Багш-суралцагчдын чадамж, Мэдээлэл Холбоо Харилцаа Технологи (МХХТ), боловсролын стандарт, гүйцэтгэлийн үнэлгээ, оношилгоо, өөрийн удирдлагатай суралцахуй, суралцахуй зорилт, мэргэжлийн хөгжлийн бүлэг, хөгжлийн хөтөлбөр, технологийн дэвшил, цахим хэрэглэгдэхүүн

Их сургуулийн орчин дахь хиймэл оюун (AI)-ы хэрэглээг зохицуулах бодлого (МУИС-ийн оюутнуудын хиймэл оюун ухааны хэрэглээний жишээн дээр)

Ц.Нэргүйбаатар¹, Б.Цэцэнжаргал², Д. Дөлгөөн³, Б. Энхнаран⁴, Б.Дэлгэрцэцэг⁵

¹УБЭИС, ulaanaa11@gmail.com

^{2,3,4,5}МУИС, ШУС-ийн оюутан, tsetsenjargalbatmunkh111@gmail.com, dulguun.d0607@gmail.com, Enhnaranbor9@gmail.com, deegiidelgertsetseg69@gmail.com

Хураангуй: Дэлхий даяар хиймэл оюун (AI) нь их, дээд сургуулийн орчинд сургалтын хэрэглэгдэхүүн болон өргөнөөр ашиглагдах болсноор дэлхийн шилдэг их сургуулиуд сургалтын хөтөлбөртөө илүү нарийн зохицуулалт хийж байна. Монголын их дээд сургуулиудын хувьд хиймэл оюуныг зөв зохистой ашиглах тогтсон зарчим байдаггүй нь оюутнууд бие даалт, эсээ, шалгалт зэргийг хиймэл оюунаар гүйцэтгүүлэн өөрийн санааг

огт тусгалгүй ашиглаж буй нь багш оюутан хоёрын дунд итгэлцлийн асуудал үүсгээд зогсохгүй академик ёс зүйн зөрчил гаргаж байгаа юм. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд МУИС-ийн оюутнуудын дунд хиймэл оюуны мэдлэг, хандлага, зан үйлийг судлан, дэлхийн шилдэг 10 их сургууль сургалтын системдээ хиймэл оюуны хэрэглээнд хэрхэн зохицуулалт хийснийг харьцуулан судлав. Судалгааны үд дүнгээс үзэн Монголын их дээд сургуулиудад хиймэл оюуны хэрэглээг зохицуулах бодлого хэрэгтэйг батлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Хиймэл оюун, оюуны хулгай, зохицуулалт, оюутан, багш, ёс зүй, их дээд сургууль

Мэргэжлийн болон Техникийн салбарын түншлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа (Барилгын салбарын жишээн дээр)

Э.Төмөрчөдөр¹

¹Дорнод Политехник коллеж

Хураангуй: Сургуулийн сүүлийн 5 жилийн статистикийн мэдээгээр Барилгын салбарын түншлэгч байгууллагуудын тоо буурсантай уялдуулан хамтын ажиллагаанд гарч буй доголдолын шалтгаануудыг илрүүлэх зорилготойгоор энэхүү судалгааны ажлыг эхлүүллээ. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зорилго нь иргэн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж, мэргэжил эзэмших, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино гэж заасан байдаг. Дорнод аймаг дахь Политехник коллеж /хуучнаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв/ нь Барилгын мэргэжлээр 2016-2023 оны хооронд 218 төгсөгчийг бэлтгэн ажлын байранд гаргасан. Дорнод аймгийн Барилга үйлдвэрлэлийн салбарт одоогийн байдлаар 10 гаруй байгууллага тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагаагаа тогтмол явуулж буй байгууллагуудаас хамтран ажиллахад тулгамдаж буй асуудлаар асуулгын аргаар судалгааг аван хамтын ажиллагааны тулгарч буй асуудлуудыг илрүүлэн, сайжруулах саналуудыг дэвшүүллээ.

Түлхүүр үг: Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа, барилгын салбар, барилгын засалч мэргэжил

Төрийн багшийн боловсролд анхаарах асуудлууд

П.Оюунтуяа¹

¹МУИС-ийн докторант, purevjaloyuntuya2@gmail.com

Хураангуй: Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулалт өгөх, зөвлөх үйл ажиллагаа юм. Үйл ажиллагаа нь дээд түвшний удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлдөг тул "Төрийн багш" хэмээн нэрлэж ирсэн уламжлалтай. Тиймээс ёс зүйг чухалчилдаг тул мэргэжлийн ёс зүйн соёлын төлөвшилтийг үнэлэн, сайжруулах шийдлийг сорилоор шалгалаа. Судалгаанд Монгол онол, академич Б.Жадамбаагийн "Нэг ертөнцийн хандлага"-д суурилж, үйлийн судалгааны арга зүй, чанарын судалгааны аргыг ашиглав. Үр дүнд нь "Төрийн багш"-ийн боловсролд анхаарч, үйл ажиллагааг нь чанаржуулах шийдлийг тодорхойлсон. Судалгаа нь Монгол Төрийн тулгуур зарчимд суурилсан онцлогтой. Заяагдмал оюун ухааныг хөгжүүлсэн шийдэлтэй. Төрийн албаны ёс зүйг сайжруулсан давуу талтай. Хүмүүнлэг нийгэм, ёс суртахуунтай шинжлэх ухааныг хөгжүүлсэн ач холбогдолтой. Квант боловсролыг нэвтрүүлсэн шинэлэг талтай.

Түлхүүр үг: Төрийн багш, дотоод аудитор, хүмүүнлэг ба хуулиа дээдлэх ёс, биет бус өв, авьяас, квант боловсрол, шинэчлэлт

Хэлний цогц ур чадварыг интеграци хичээлээр хөгжүүлэх нь

А.Баттуяа¹, Б.Цэнд-Аюуш²

^{1,2}Барилгын политехник коллеж, tsend-ayush@cc.edu.mn

Хураангуй: Шинэ зууны боловсрол, сургалтыг амжилттай зохион байгуулж, ирээдүйд өрсөлдөн амьдрах чадвартай, насан туршийн боловсролтой иргэнийг бэлдэхийн тулд орчин үеийн боловсрол судлал, суралцахуйн онолын үзэл санаа, хөгжлийн чиг хандлагыг хэрэгжүүлэх учиртай. Мөн энэ үеийн хүүхдүүдэд нэг зүйлийг олон талаас илэрхийлдэг эсвэл олон зүйлийг нэгтгэн дүгнэлтэд хүрдэг байх олон талын чадварыг байнга шаардаж байгаа нь нийгмээс ажиглагдана. Энэ нь интеграци гэсэн үгийн утгатай нийцэж байна. Тиймээс бид Generation Alpha үеийн суралцагчдад тэдний хэрэгцээнд тулгуурлан багш бүр өөрийн арга зүй, арга барилаа өөрчлөх шаардлага тулгарч байна. Мөн интеграцилах, интеграци хичээл гэсэн ойлголт боловсролын салбарт нэлээн яригдаж байгаа учир илтгэлийн сэдэвтэй уялдуулан сонгон судалсан. Энэхүү ажлын зорилго хэлний цогц ур чадварыг интеграци хичээлээр дамжуулан хөгжүүлэх боломжийг эрэлхийлж туршихад оршино. 1. Суралцагчдын оношлох үнэлгээний үр дүнд хэлний цогц чадварын нөхцөл байдлыг тогтоох 2. Интеграцийн ухагдахуунд суурилж, англи болон монгол хэлний хичээлийн агуулгыг интеграцлан хэрэгжүүлэх 3. Интеграци хичээлийн үр дүнг тооцох гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Түлхүүр үг: Интеграци, хэлний цогц чадвар

“Тогтвортой хөгжлийн үзэл санааг”-г нийгэм судлал хичээлээр дамжуулан бусад хичээлтэй интеграцилах боломж (8-р ангийн төсөлт ажил болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны жишээн дээр)

Ч.Ариунтуяа¹, М. Оюундалай², Ч. Нямбуян³, Д.Даваасүрэн⁴, Б.Содном⁵
^{1,2,3,4,5} Хөвсгөл, Ирээдүй 21-р зуун сургууль

Хураангуй: МУЗГ-ын 2016-01-11 ний өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” МУЗГ-ын 2018-7-4 өдрийн 209 дугаар тогтоолоор “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр, УИХ-аас 2015 онд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, зэрэг манай улсад хэрэгжиж байгаа хууль, тогтоомжууд дээр үндэслэн өөрсдийн зааж байгаа нийгэм судлал хичээлийн агуулгын хүрээнд тогтвортой хөгжлийн үзэл санааг интеграцилах боломжийг судлахаар энэхүү илтгэлээ бичихээр зорьсон.

НҮБ нь харилцан уялдаа бүхий ТХ-ийн 17 зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд боловсролын гүйцэтгэх үүргийг тодотгон үзэж байгаа бөгөөд тэр тусмаа ТХЗ-ын 4 болох “Чанартай боловсрол”-ыг салшгүй нэг хэсэг төдийгүй ТХ-ийн бусад бүх зорилгыг хэрэгжүүлэх гол идэвхжүүлэгч” гэж тэмдэглэсэн байдаг. Тиймээс багш бидний зүгээс сурагчдадаа чанартай боловсролыг олгохын тулд нийгэм судлал хичээлийн агуулгын хүрээнд тогтвортой хөгжлийн үзэл санааг интеграцилж, цаашлаад ээлжит хичээл болон сайн дурын төсөлт ажлууд, ХГС-танд арга зүйгээ оновчтой хэрэгжүүлэн сайн үр дүнд хүрсэн байх эрэлт хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Учир нь “Тогтвортой хөгжил бол хүн бүрд хамаатай, газар бүр хэрэгжих учиртай, нийгэм бүхэлдээ өөрчлөн шинэчлэгдэх үйл явц байдаг бөгөөд тогтвортой хөгжлийн боловсрол бол түүнийг шинэчлэн хэрэгжүүлэх арга зам” хэмээн үзэж байна. Тэр ч утгаараа сурагчдыг байгаль орчиндоо ээлтэй, амьдрах орчноо хайрлан хамгаалдаг иргэн бэлтгэх зорилготой багш хүний хувьд хичээлүүдийн хоорондох уялдаа холбоог бэхжүүлж сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөх нь зайлшгүй юм.

Түлхүүр үг: Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд, Тогтвортой хөгжлийн боловсрол, Хичээлийн интеграци, Төсөлт ажил, ХГС

ЕБС-иудын ба багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд хийсэн шинжилгээ

С.Галбадрах¹, М.Энхсайхан²

¹Удирдлагын Академи, Galaa5@yahoo.com

²Удирдлагын академийн магистрант, m.enhsaihan2021@gmail.com

Хураангуй: Монгол Улсын бага дунд боловсролд 2022 оноос хэрэгжсэн ЕБС-иудын ба багшийн ба гүйцэтгэлийн үнэлгээний улсын хэмжээний тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн судаллаа. Судалгаанаас үзэхэд гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь жилээс жилд өөрчлөгдөж иржээ. Судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд 2022-2024 онуудын ЕБС ба багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь өссөн үзүүлэлттэй байна. Судалгааг ЕБС ба багш нарын хот хөдөөгийн байршлаар авч үзэв. Судалгаагаар нийслэл ба аймгийн төв, сум багийн түвшинд ЕБС ба багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд ялгаатай байдал илэрч байна. Ялангуяа ЕБС-иудын гүйцэтгэлийн үнэлгээнд хот хөдөөгийн ялгаатай байдлын түвшин өндөр байна. Уг судалгаанд гүйцэтгэлийн үнэлгээнд дараалан 3 жил хамрагдсан ЕБС-иудын 16785 багшийн үнэлгээний үр дүнгийн өөрчлөлтийг өмнөх жилийн үзүүлсэн үнэлгээний үр дүнтэй уялдуулан судалж зүй тогтлыг тодорхойллоо. Мөн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн багш нарын ажлаас гарах шийдвэрт хэрхэн нөлөөлсөн болохыг энэхүү судалгаагаар харуулав.

Түлхүүр үг: Үр дүнд суурилсан санхүүжилт, багшийн ажлын үнэлгээ, үр дүнгийн урамшуулал, боловсролын салбарын шинэчлэл, боловсролын үйлчилгээн дэх хот хөдөөгийн ялгаа

Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг хиймэл оюун ашиглан үнэлэх боломж

Б.Амартогтох¹

¹ДХИС, Дотоод чанарын баталгаажуулалтын төв, amartogtokhbattulga@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгаагаар хиймэл оюун ашиглан хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг үнэлэх боломжийг судалсан. Хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг үнэлэхдээ суралцахуйн үр дүн, агуулга, арга, хэрэглэгдэхүүн, үнэлгээ гэсэн үндсэн 5 хэсгийг 34 шалгуурын дагуу тус бүр 0-4 онооны рубрик боловсруулан багшийн өөрийн үнэлгээ, мэргэжилтэнгийн (боловсрол судлаач) хөндлөнгийн үнэлгээ, хиймэл оюуны хөндлөнгийн үнэлгээнүүдийг 2 хичээл тус бүрт хийж харьцуулсан дүгнэлтүүдийг гаргасан. Өгөгдлийн боловсруулалтыг SPSS программыг ашиглан үнэлгээний аргачлалын дотоод найдвартай байдлын шинжилгээ (Кронбахын альфа), үнэлгээний үр дүнгийн ялгаатай байдлын шинжилгээ (Paired Samples T-test), үнэлгээний тайлбарын агуулгын харьцуулсан шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үнэлгээний аргачлалын дотоод найдвартай байдлын шинжилгээний үр дүнд үндсэн 4 хэсгийн 28 шалгуур найдвартай (сүд $\alpha = .802$, агуулга $\alpha = .723$, хэрэглэгдэхүүн $\alpha = .810$, үнэлгээ $\alpha = .822$) харин сургалтын аргыг үнэлэх шалгуур найдваргүй ($\alpha = 0.286$) гарсан учраас судалгааны үр дүнгээс хасаж үр дүнг боловсруулсан. Үнэлгээний үр дүнгүүдийн ялгаатай байдлын шинжилгээгээр ((Paired Samples T-test) мэргэжилтэнгийн хөндлөнгийн үнэлгээний үр дүн, хиймэл оюуны /Claude AI 3.7/ хөндлөнгийн үнэлгээний үр дүнгийн ялгаатай байдал ач холболгүй (хичээл-1 $p = 0.345$, хичээл-2 $p = 0.354$) буюу үнэлгээний үр дүн хоорондоо төстэй, харин хиймэл оюун болон багшийн өөрийн үнэлгээний үр дүнгийн ялгаатай байдал ач холболтой (хичээл-1 $p = 0.002$, хичээл-2 $p = 0.004$) буюу үнэлгээний үр дүнгүүд хоорондоо төстэй биш байна. Мөн үнэлгээний тайлбарын агуулгын шинжилгээгээр мэргэжилтэн болон хиймэл оюуны үнэлгээний тайлбар мөн хоорондоо төстэй (хичээл -1 хувьд 17 шалгуур, хичээл-2 хувьд 21 шалгуур) байна. Энэхүү үр дүнгүүдээс

дүгнэхэд хиймэл оюуныг хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг үнэлэхэд хөндлөнгийн үнэлгээ хэлбэрээр ашиглах боломжтойг тогтоолоо.

Түлхүүр үг: Хиймэл оюун, хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, өөрийн үнэлгээ

Суралцагчийн онцлогт тулгуурлан боловсруулсан сургалтын аргын нэгэн хувилбарыг туршсан байдал

Ш.Ариунбаяр¹

¹МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ariunbayarsj@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгаанд Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчдын сурах хэв маягийг тодорхойлж тэдний онцлогт тохирсон сургалтын аргын нэгэн хувилбарыг боловсруулан туршсан үр дүнг танилцуулах болно. Судалгаанд нийт 55 суралцагч хамрагдсан ба нийт суралцагчийн суралцах хэв маягийг тодорхойлж, хяналтын бүлэгт 29 болон туршилтын бүлэгт 26 суралцагч сонгон авав. Туршилтын бүлгийн суралцагчдад суралцах хэв маяг дээр тулгуурлан “Хувиргалт” сэдвийн хүрээнд туршилтын гурван удаагийн хичээл явуулсан ба өмнөх мэдлэг дээр тулгуурласан оношлох болон ахицыг үнэлсэн дүн шинжилгээ хийхэд дүн 48.69 байсан бол 52,76 болж өссөн үзүүлэлттэй гарлаа. Эндээс суралцагчийн сурах хэв маяг тулгуурлан боловсруулсан сургалтын арга үр дүнтэй байгаа нь харагдаж байна.

Түлхүүр үг: Сурах хэв маяг, ур чадвар, сонорын, харааны, хүрэлцэх

Бакалаврын судалгааны ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг машин сургалтын бүлэглэх арга ашиглан шинжлэх нь

М.Амарзаяа¹, Б.Наранбат², М.Золжаргал³, Б.Наранчимэг⁴

^{1,2,3,4}МУИС, МТЭС, 23M1NUM0810@stud.num.edu.mn, naranbat@num.edu.mn, zoljargal@num.edu.mn, naranchimeg@num.edu.mn

Хураангуй: Бакалаврын судалгааны ажил нь оюутны их сургуулийн боловсролыг дүгнэх, эзэмшсэн мэдлэг чадварыг бодитоор хэрэгжүүлэх чухал судалгааны бүтээл юм. Энэ нь оюутанд мэргэжлийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, чадварыг бататгах, судалгаа шинжилгээний арга барилд суралцах, бие даан ажиллах, асуудлыг шинжлэх, дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх боломж олгодог. Сайн боловсруулсан бүтээл нь нь карьер эхлүүлэх, ахисан түвшинд судалгаагаа үргэлжлүүлэх гол түлхүүр болно. Харамсалтай нь олон тооны оюутнууд судалгааны ажлаа хугацаандаа дуусгадаггүй, эсвэл дутуу хэрэгжүүлснээр хангалттай дүн авч чаддаггүй байна. Оюутнууд судалгааны ажлын явцад сэдэв сонголт, эзэмшсэн мэдлэгийн хүрээ, судалгааны арга зүй, цагийн зохион байгуулалт зэрэг олон төрлийн бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс энэхүү судалгаанд бакалаврын судалгааны ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг машин сургалтын бүлэглэх арга болон энгийн статистикийн шинжилгээний аргыг ашиглан тодорхойлон тайлбарлахыг зорилоо. Энэхүү судалгаанд 2023-2024 оны Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн Технологийн чиглэлийн дөрвөн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын бакалаврын судалгааны ажлын өгөгдөл, суралцсан хугацааны хичээлийн дүнгийн өгөгдөл зэргийг цуглуулан боловсруулж өгөгдлийн багцыг (нийт 267 оюутан) бүрдүүлсэн. Бакалаврын судалгааны ажилд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлохдоо уламжлалт статистикийн шинжилгээ (корреляцийн шинжилгээ) болон машин сургалтын бүлэглэх (clustering) аргыг ашигласан. Үр дүнгээс харахад БСА-ын гүйцэтгэлд мэргэжлийн хичээлийн дүн, явцын үнэлгээний дүн, сэдвийн сонголт зэрэг нь тодорхой нөлөөтэй байгаа бол багшийн нөлөө харьцангуй бага гэж тодорхойлогдлоо.

Түлхүүр үг: Өгөгдлийн шинжилгээ, бакалаврын судалгааны ажил, машин сургалтын бүлэглэх арга, clustering, корреляцийн шинжилгээ

Боловсролын ноксологи ба эрсдэлийн менежмент

З.Бямбасүрэн¹

¹МУИС, ШУС-ийн докторант, Zandanbyambaa01@gmail.com

Хураангуй: Монгол Улсад Боловсролын салбарт, ялангуяа ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, төлөвлөлт хангалтгүй байгааг судлах нь өнөөгийн нийгмийн чухал асуудлуудын нэг юм. Энэ асуудал нь боловсролын салбарт зөвхөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) тухай хууль, эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдаж, сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нарийвчилсан, тодорхой бодлого, стратеги хангалтгүй байна. Иймд ерөнхий боловсролын дунд сургуулийн орчин, нөхцөлд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрсдэлийн менежментийн талаарх ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүллэг, эрх бүхий байгууллагаас гаргасан удирдамж, боловсролын салбарт хэрэгжүүлж буй стандарт, мөн олон улсын эрсдэлийн удирдлагын онол арга зүйн чиг хандлага, хэрэгжүүлж буй туршлага судлан, харьцуулсан судалгаа хийж Боловсролын салбарын аюулгүй байдал, эрсдэлийн менежментийн стратеги загварыг боловсруулав.

Түлхүүр үг: Аюул, эрсдэл, хяналт, осол гэмтэл, менежмент, ноксологи, боловсрол, эрсдэлийн үнэлгээ

Завхан аймгийн ЕБС-иудын багшийн дутагдал, цаашдын хандлага, бууруулах арга зам

Ж.Норолхоожав¹, Ж.Эрдэнэзаяа²

Хураангуй: Боловсролын салбарын үйл ажиллагаа, боловсрол олгох үйл явц нь аливаа улс, үндэстний нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйлийн нэг юм. Багш бол боловсролын үйл явцад нөлөөлөх үндсэн субъектийн нэг тул бүх түвшний боловсролын байгууллагуудын хувьд багшийн үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, тэдний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэрийг оновчтой болгох нь чухал. Иймээс бүх шатны боловсролын байгууллагын хувьд боловсролын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нь багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамжтай шууд хамааралтай юм. ЕБС-ийн багшийн дутагдалтай байдал нь тухайн сургуулиудад багш хангалтгүй байгаа, эсвэл шаардлагатай мэргэжлийн чиглэлээр багш байхгүй байгааг харуулж байгаа юм. Тухайн сэдвийг судлах болсон шалтгаан нь

1. Боловсролын чанартай шууд хамааралтай

- ЕБС-ийн боловсролын чанарыг хамгийн голд нь авч үзвэл багш бол гол түлхүүр хүчин зүйл юм. Чадварлаг, мэргэжлийн багшгүйгээр сурагчдын сурлагын амжилт, бүтээлч сэтгэлгээ хөгжих боломж хомс. бөгөөд хот, хөдөөгийн багшийн хангамжийн ялгаа, зарим мэргэжлийн (жишээ нь физик, математик, англи хэл) багшийн хомсдол нь боловсролын тэгш бус байдалд хүргэж байна.

2. Багш мэргэжлийн сонирхол буурч байна

- Сүүлийн жилүүдэд их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгчдийн тоо буурсан, төгсөгчдийн дийлэнх нь өөр салбарт ажиллах хандлагатай байна.

- Энэ нөхцөл байдлыг үндэслэлтэй ойлгож, залуу боловсон хүчнийг татах бодлого боловсруулахад анхаарлаа хандуулах нь чухал байна. Эдгээр шалтгааны улмаас тухайн сэдвийг сонгон авч Завхан аймгийн ЕБС-ийн багшлах боловсон хүчний хүртээмжтэй байдал, хүрэлцээ хангамжийн талаарх судалгааг хийхийг зорьсон.

Гүн сургалтын seq2seq загварт тулгуурлаж Англи-Монгол нейроны машин орчуулгыг сайжруулах нь

Д.Чулуунцэцэг^{1,2}, Б.Туяацэцэг²

¹Төмөр замын дээд сургууль, chuka_tzd@yahoo.com

²ШУТИС, Tuyatsetseg.b@must.edu.mn

Хураангуй: Хиймэл оюун ухаан өдөр тутмын амьдралд хаа сайгүй нэвтэрч байна. Нейроны сүлжээний санд суурилсан гүн сургалтын Keras Tensorflow сангуудыг ашиглан дүрс таниулах, галт тэрэгний чингэлэгийн дугаарыг таниулах туршилтуудыг явуулж байсан [19]. Түүнчлэн, эдгээр сангуудыг эх хэлний боловсруулалтанд ашиглах боломжийг судалж, KerasNLP дээр суурилсан гүн сургалтын sequence-to-sequence (SEQ2SEQ) трансформер загварт тулгуурлан англи-монгол хэлний (EN-MN) орчуулгын чанарыг сайжруулахад ашиглах зорилго тавьж ажилласан. Хиймэл оюуны машин орчуулга нь өгөгдөлд тулгуурласан машин орчуулгын арга бөгөөд корпусын нөөц хангалтгүй үед орчуулгыг сайжруулах боломжтой хэвээр байна. Wikimatrix болон бусад нээлттэй эхүүдэд EN-MN корпусын нөөц хангалтгүй учраас англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлсэн 1200000 гаруй мөр бүхий корпусыг механик аргаар болон нээлттэй эхүүдийг ашиглан бэлтгэлээ. Орчуулгыг үр дүнг сайжруулахын тулд sequence-to-sequence трансформерын загвар дээр тулгуурлан суурь загварыг бүтээж 1200000 гаруй хос өгөгдлийг сурган N=10 (сургалтын үе) ба epochs = 20 байхаар туршилтыг явуулж BLEU –ийн дундаж утгыг 66.9 үр дүнд хүргэсэн.

Түлхүүр үг: Хиймэл оюун ухаан, дүрс таних, машин орчуулга, трансформер, өөртөө анхаарал хандуулах

“Хөгжлийн бэрхшээлийг ойлгоё” хичээлийн зарим үр дүнгээс (4 дүгээр ангийн жишээн дээр)

Л.Мөнхтуул¹

¹Шинэ Монгол Харүмафүжи сургууль, munkhtuul@shinemongol.edu.mn

Хураангуй: Дэлхийн олон оронд хөгжлийн бэрхшээлийг ойлгох, хүлээн зөвшөөрөх боловсрол чухалд тооцогддог бөгөөд сургуулиудын хөтөлбөрт тусгай хичээлүүд болон интеграцлагдсан сэдвүүдийг тусгасан байдаг. Эдгээр хичээл нь хүүхдэд хүн бүрийн ялгааг хүндэтгэх, олон төрлийн чадвартай хүмүүстэй ойлголцож харилцах чадвар төлөвшүүлэхэд чиглэдэг (UNESCO, 2017). Жишээлбэл, Японы бага сургуульд «Barrier-Free Mind» хичээлээр сурагчид хөгжлийн бэрхшээлтэй хүний оронд өөрийгөө тавьж ойлгох дадлага хийдэг. Финляндын сургуулиудад “Хүн бүр өөр өөр, тэгш эрхтэй” сэдвийн хүрээнд ялгаатай чадвартай хүмүүстэй харилцах хичээл ордог бол АНУ-д “Inclusive Education” буюу хамтран сурах орчны хичээлүүд хөтөлбөрт багтсан байдаг (U.S.Department of Education, 2020). Монгол Улсад дээрх сургалтын туршлагаас санаа авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ойлгох хандлагыг бага боловсролын түвшинд төлөвшүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлийг ойлгоё” цуврал хичээлийг 4-р ангид туршин заасан. Уг хичээлийн агуулгыг иргэний ёс зүйн боловсрол судлагдахууны хөтөлбөртэй уялдуулсан бөгөөд сурагчдад үзүүлсэн нөлөөллийг судлан дүгнэсэн болно. Судалгааны үр дүнгээс харахад, уг хичээлийг үзсэний дараа 10 настай хүүхдүүдийн юмсыг харах өнцөг өөрчлөгдөж, бусдыг хайрлах, энэрэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөв харилцах, тэдэнд туслах энгийн арга барилд суралцсан нь тодорхой болсон. Мөн бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагад эерэг нөлөө үзүүлсэн байна.

Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээл, ялгаатай байдлыг ойлгох, бага боловсрол, биеэр мэдрэх хичээл

Холболтын дүрэм ашиглан хичээлүүдийн дүнгийн хамаарлыг шинжилж, хөтөлбөрийг сайжруулах боломжийг судлах нь

Б.Наранчимэг¹, А.Баатарбилэг², П.Гантуяа³

^{1,3}МУИС, МТЭС, naranchimeg@num.edu.mn, gantuya.p@num.edu.mn

²МУИС, Цахим шилжилтийн газар, a_bbileg@num.edu.mn

Хураангуй: Энэ судалгааны зорилго нь өгөгдөл олборлолтын холболтын дүрэм (association rule) ашиглан оюутнуудын хичээлийн үнэлгээ хоорондын хамаарлыг тодорхойлох явдал юм. Ингэснээр оюутныг үйцэтгэлийг урьдчилан таамаглах, хичээлийн ачааллыг зохицуулах цаашлаад сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэрэг боловсролын чанарыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой. Судалгаанд Монгол улсын их сургуулийн Мэдээллийн технологи бакалаврын хөтөлбөрийн 5 жилийн туршид хуримтлагдсан оюутнуудын хичээл ба үнэлгээний өгөгдлийг ашиглав. Apriori алгоритмын тусламжтайгаар хичээлүүдийн үнэлгээний давтамж болон хоорондын давхцал дээр үндэслэн хамаарлын дүрмүүдийг гаргасан. Түүнчлэн дээрх аргаар F үнэлгээний давтамж болон хоорондын давхцал дээр үндэслэн амжилтгүй суралцах хамаарлын дүрмүүдийг гаргав. Судалгааны үр дүнд, жишээлбэл, "ICSI314 дээр А авсан авсан оюутнуудын 83% нь INTE402 хичээлд мөн А авсан" гэх мэт өндөр итгэлцүүр бүхий дүрмүүд илэрсэн. Энэ нь хичээлүүдийн агуулгын уялдаа, оюутны чадварын чиг хандлага, болон сургалтын төлөвлөгөөг оновчтой болгоход үнэтэй мэдээлэл өгч байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Association rule mining, apriori алгоритм, сургалтын чанар, суралцагчдын үнэлгээ хоорондын хамаарал, холболтын дүрэм, боловсролын өгөгдөл шинжилгээ

Ерөнхий боловсролын сургалтад ирээдүйгээс эргэн төлөвлөх (backcasting) аргыг хэрэглэх нь: тохиолдлын судалгаа

Б.Ганбат¹, О.Цэцэгбал², М.Ундрэм³, Э.Мөнгөнтулга⁴, М.Мөнгөнтуул⁵, Б.Мөнхнасан⁶

¹Олон улсын эрүүл мэндийн бодлого, үр дүнгийн судалгаа нийгэмлэг (ISPOR), gbtbya@gmail.com

²Монгол Улсын Боловсролын сайдын зөвлөх, tsetsegbal.dr@gmail.com

³Нотолгоонд суурилсан анагаах ухааны боловсролын институт, undram@gmail.com

⁴МУБИС, МБУС, munguntulga@msue.edu.mn

⁵УБ, 17 дугаар сургууль, munguu5dmbb@gmail.com

⁶УБ, 23 дугаар сургууль, munhnasanbyambadorj@gmail.com

Хураангуй: Тогтвортой хөгжилд чиглэсэн боловсрол (ESD)-ын хүрээнд сурагчдын ирээдүйд чиглэсэн ур чадваруудыг хөгжүүлэх, ирээдүйг төсөөлөх, урт хугацааны үр дагаврыг ойлгох, шүүмжлэлтэй сэтгэх зэрэг чадваруудыг бага наснаас нь төлөвшүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна [1]. Ирээдүйгээс эргэн төлөвлөх (ИЭТ) нь ирээдүйгээс өнөөдөр рүү чиглэсэн төлөвлөлтийн арга бөгөөд бага ангийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсролыг шинэчилсэн, бүтээлч байдлаар эзэмшүүлэх оновчтой арга хэмээн тооцогдох болсон. Түүхэн талаасаа ИЭТ аргыг анх тогтвортой хөгжил, эрчим хүчний менежмент, хот төлөвлөлт зэрэг салбаруудад хэрэглэж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд боловсролын салбарт өргөнөөр ашиглаж байна. Энэ аргаар сурагчдад урт хугацааны нөлөөллийг ойлгуулах, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлэх, хамтран суралцах үйл явцыг дэмжих ач холбогдолтой. 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжих бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бид Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг энэхүү Ирээдүйгээс эргэн төлөвлөх арга зүйн дагуу боловсруулсан бөгөөд арга зүйн туршилт судалгааны үр дүнгээс тоймлон энэхүү илтгэлийг хэлэлцүүлж байна.

Түлхүүр үг: Бага боловсрол, Эрүүл мэндийн хичээл, Ирээдүйгээс эргэн төлөвлөх арга

Оюутнуудын бие хүний их таван шинжийг судалсан үр дүн

Б.Дорж¹

¹МУИС, Ховд сургууль, Dorjbattulga2@gmail.com

Хураангуй: Хувийн онцлогийг бүрдүүлэгч төрөл бүрийн шинжүүдийг факторын анализын аргаар судалсаны үндсэн дээр үндсэндээ таван бүлэгт хуваагдаж байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэхүү таван бүлэг шинжид хувь хүний сэтгэл зүйн онцлогийг бүхэлд нь хамруулан тодорхойлж болно гэж үзэж байгаа бөгөөд эдгээрийг орчин үеийн сэтгэл судлалын шинжлэх ухаанд “Их тав” (the big five) гэж нэрлэх болжээ [1]. Судалгаагаар тодорхойлох зан төлөвшлийн их 5 онцлог:

- Нийцтэй зан ба дайсагнасан зан (Agreeableness.vs.hostility)
- Экстраверт болон интроверт (Extraversion.vs.introversion)
- Эмх цэгцтэй ба цэгцгүй зан (Conscientiousness .vs. impulsivity)
- Сэтгэлийн тогтвортой болон тогтворгүй байдал (Neuroticism.vs. emotional stability)
- Нийцтэй зан ба дайсагнасан зан (Agreeableness.vs.hostility)

Монгол оюутнуудын их тавын онцлогийг судалж, өмнө хийгдсэн судалгааны ажлуудтай харьцуулан дүгнэсэн.

Түлхүүр үг: оюутнуудын сэтгэл зүйн онцлог, бие хүний шинж, их тав

Нийгэм сэтгэл хөдлөлийн чадамжийг ээлжит хичээлээр төлөвшүүлэх нь (6-р ангийн англи хэл, эрүүл мэндийн интеграц хичээлийн жишээн дээр)

А.Мөнхтуяа¹, Б.Дашням², Д.Эрдэнэтуяа³, Э.Бямбахишиг⁴, Б.Нандинцэцэг⁵,
Б.Амаржаргал⁶, Ж.Үүрдмөнх⁷, Э.Болорцэцэг⁸, Ж.Цэрэнханд⁹
^{1,2,3,4,5,6,7,8,9}Дундговь, Мандал сургууль, munkhtuyamgalan99@gmail.com,

Хураангуй: Өнөөдөр дэлхий дахинаа болон манай улсад сэтгэцийн эрүүл мэндийн асуудал тулгамдаж буй асуудлын нэгж болсон. Боловсролын яамнаас 2024-2025 оны хичээлийн жилийн зорилгыг “Суралцагчийн эзэмших чадамж (...эрүүл мэнд, нийгэм сэтгэл хөдлөл)-ийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж хичээл сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулна” гэж тодорхойлсон.Мандал сургуулийн VI ангиудын 35 хувь нь V анги төгсөөд математикийн төрөлжсөн сургалттай сургууль руу шилжсэн,эрэгтэй сурагчийн тоо 65.5 хувийг эзэлдэг, шинээр ангийн багштай болсон, зарим сайн найзууд нь өөр сургууль руу шилжсэн, анги хамт олны уур амьсгал бүрдээгүй байдаг. 2024 оны 09 сард хийсэн англи хэлний багш нарын ажиглалтын болон нийгмийн ажилтны III-XII ангийн 631 хүүхдийг хамруулсан “Үе тэнгийн дээрлэлтийн судалгаа”-аар 40-78 хүртэл хувь нь бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авдаг, хичээлийн бэлтгэлгүй ирдэг, анхаарал төвлөрөлт тааруу, талархлаа илэрхийлдэггүй, бусдад хүндэтгэлгүй ханддаг (доромжлох, нэр хоч өгөх, бусдын биед зөвшөөрөлгүй хүрэх гэх мэт), хичээлд тусалдаггүй гэсэн сөрөг зан үйлүүд илэрсэн. Дээр дурдсан бодлогын баримт бичиг, тулгамдаж буй асуудал нь нийгэм сэтгэл хөдлөлийн чадамжийг өдөр тутмын хичээл сургалтад төлөвшүүлэх хэрэгцээ үүссэн.Энэхүү судалгааны ажлаар бид нийгэм сэтгэл хөдлөлийн боловсролын үндсийг тогтвортой хөгжил, 21 дүгээр зууны боловсролын чадваруудтай харьцуулан судалж, англи хэл, эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийн шинжилгээ хийн холбоо хамаарлын матрицыг гаргасан бөгөөд нийгэм сэтгэл хөдлөлийн чадамж төлөвшүүлэх үйл ажиллагааг Дундговь аймгийн Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Мандал сургуулийн VI ангийн 3 бүлгийн 90 суралцагчид ээлжит болон судалгаат хичээлээр туршиж хэрэгжүүлсэн байдал, хүүхдэд гарсан ахиц

өөрчлөлтийг танилцуулах болно.

**Хөгжмийн мэргэжлийн суралцагчдад тулгамдаж буй зарим асуудал
(Хийл хөгжмийн жишээн дээр)**

Э.Энхцэцэг¹

МУБИС-ийн докторант, tseegiihbkg@gmail.com

Хураангуй: This study aims to examine the issues faced by string instrument students studying at music schools in Mongolia. A total of 35 participants took part in the study, identifying 10 types of risk factors. These risks have been categorized into three groups: those dependent on the family, changes in physical development, and issues related to social interactions. Notably, it was found that the risk associated with muscle system injuries is particularly high among students. Moving forward, it is necessary to develop and implement training programs and courses specifically designed for teachers and students in this area. The study confirms the necessity of developing new methodologies to prevent musculoskeletal injuries among students in professional music training.

Түлхүүр үг: мэргэжлийн хөгжмийн сургалт, булчингийн тогтолцооны эмгэг, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйл

Физик, математикийн агуулгыг интеграцчилан заасан хичээл нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх эсэхийг судалсан нь

Б.Дэлгэрцэцэг¹, С.Энхмандах², М.Сосорбурам³

^{1,2,3} Улаанбаатар, 141 дүгээр сургууль

Хураангуй: Физикийн "Зөв хэлбэртэй биеийн эзлэхүүнийг хэмжих" агуулгыг математикийн

"Бүхэл тооны куб зэрэг, куб язгуур" агуулгатай интеграцчилсан хөтөлбөр бэлдэж туршилтын бүлэгт 80 минутын хичээл заасан. Интеграцчилсан хөтөлбөрөөр хичээл орох нь хүүхдийн ой тогтоолтод хэр үлдсэнийг илрүүлэхэд чиглэсэн сэргээн санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, дүгнэлт гаргах танин мэдэхүйн процессыг үнэлэх боломжтой Блүмийн таксономи сонгон авч интеграцчилсан хөтөлбөрт тохируулан үнэлгээний даалгавар бэлдэж, үнэлгээ авч дүгнэлт гаргасан. Ингэхдээ интерацчилсан хөтөлбөрөөр хичээл заасан туршилтын бүлэг болон интерацлаагүй хяналтын бүлэгт ижил үнэлгээний даалгавар өгч ажиллуулсан. Даалгаврын гүйцэтгэлд суурилан танин мэдэхүйн түвшний харьцуулалт хийх аргаар интерацчилсан хичээл заах нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжил, асуудал шийдвэрлэх чадвар, сурах идэвхийг нэмэгдүүлсэн эсэхэд үнэлэлт гаргасан. Судалгааны үр дүндээ анализ хийж дүгнэлт гаргаад, улмаар өдөр тутмын хичээл сургалтын үйл ажиллагаандаа шинэ санаа, анхаарах зүйлсийг нэгтгэн авч ашигласан.

Түлхүүр үг: интеграци, танин мэдэхүй, блүм таксономи

Шууд сургалтын загвар ашиглан геогебра ангиар туршсан танхимын сургалтын үйл ажиллагааны үр дүн (V ангийн тэнхлэгийн тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлт хичээлүүдийн жишээн дээр)

С.Мягмарлхам¹, Ц.Навчаа²

¹Монгени Цогцолбор Сургууль, myagaa.0329@gmail.com,

²МУИС, ШУС, navchaa@smcs.num.edu.mn

Хураангуй: Бага ангийн математикийн хичээлд динамик хэрэглэгдэхүүнийг ашиглах нь сурагчдын оролцоог нэмэгдүүлж, ухагдахууны мэдлэгийг хөгжүүлэх

чухал ач холбогдолтой. Энэхүү судалгааны зорилго нь шууд сургалтын загвараар V ангийн "тэнхлэгийн тэгш хэм, параллел зөөлт, эргүүлэлт" хичээлүүдийг интерактив ГеоГебра ангид туршин хэрэгжүүлснээр багшийн багшлахуй, сурагчийн суралцахуйн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох болно. Судалгаанд А сургуулийн бага ангийн багш, 5* ангийн 45 сурагч хамрагдсан. Хичээл заах багш, зөвлөх болон хэрэглэгдэхүүн боловсруулах багштай хамтран ажиллаж тус хичээлүүдийн дөрвөн үе шат бүхий иж бүрэн динамик хэрэглэгдэхүүн бүхий номыг боловсруулж, ГеоГебра анги үүсгэн хичээлүүдийг зохион байгуулсан. Хичээл бүрийн видео бичлэгүүд (үүнд интерактив хэрэглэгдэхүүний дэлгэцийн бичлэг, ГеоГебра ангид багшилж буй багшийн үйл ажиллагаа болон суралцаж буй сурагчдын үйл ажиллагааны бичлэг)-ийг хийсэн ба сурагчдын даалгавар бүрийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн байдлын мэдээллийг цуглуулсан. Турших, ажиглах, видео анализын аргуудыг ашиглан хичээлүүдийн үр дүнг боловсруулсан. Судалгааны үр дүнд ГеоГебра ангийг ашиглан орсон танхимын математикийн хичээл нь бага ангийн багш, сурагчдын хувьд шинэлэг, сонирхолтой, идэвхжүүлсэн, хамтын болон бие даасан бүтээлч, логик сэтгэлгээгээр ухагдахууны мэдлэгээ эзэмшиж байгаа нь багшийн багшлахуй, сурагчдын суралцахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж сургалтын үр дүн сайжрах боломж бий гэж үзэж байна.

Түлхүүр үг: шууд сургалтын загвар, ГеоГебра анги, сургалтын үйл ажиллагаан өөрчлөлт гарч буйг судлах болно.

Монголын химийн сургалтын цөм хөтөлбөр болон Кембрижийн химийн хөтөлбөрийн суралцахуйн зорилтын агуулга, бүтцийн харьцуулсан судалгаа

П.Нямдэмбэрэл¹, Ч.Нямгэрэл²

¹Сингапур скүүл оф Монголия, nymdemberel12@gmail.com

²МУИС, Шинжлэх Ухааны сургууль, nyamgerel@num.edu.mn

Хураангуй: Энэхүү судалгаагаар Монголын химийн сургалтын цөм хөтөлбөр болон Кембрижийн химийн хөтөлбөрийг баримт бичгийн түвшинд харьцуулан, суралцахуйн зорилт, агуулгын бүтцийг тодорхойлсон. Судалгаа нь "curriculum as intended" буюу албан ёсны баримт бичгийн түвшинд хийгдсэн бөгөөд баримт бичгийн шинжилгээ, агуулгын зураглал, үнэлэгчдийн найдвартай байдлын хэмжүүр (Intraclass Correlation Coefficient – ICC, Cronbach's Alpha)-ийг ашигласан. Хоёр хөтөлбөрөөс нийт 463 суралцахуйн зорилтыг суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд задлан шинжилсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд хоёр хөтөлбөрийн хооронд утга агуулгын давхцал ажиглагдсан. Тодруулбал, Монголын цөм хөтөлбөрийн 371 зорилт Кембрижийн суралцахуйн зорилтуудтай бүрэн нийцэж байгаа нь агуулгын давхцал байгааг илтгэнэ. Мөн Кембрижийн хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудтай давхцаагүй цөм хөтөлбөрийн СЗ-ууд нь үндэсний онцлогийг тусгасан. "Хими ба амьдрал" (6–8-р анги), "Түлш" (10-р анги) зэрэг бүлэг дэх нүүрс, биотүлш зэрэг сэдвүүд нь Монголын байгаль, эдийн засгийн онцлогийг агуулсан байв. Мөн бүтэц, агуулгын дарааллын хувьд зөрүү ажиглагдсан. Кембрижийн хөтөлбөр нь спираль бүтэцтэй, цөм хөтөлбөрийн хувьд мөн ижил боловч зарим ангид сэдэв хоорондын агуулга хуваагдсан байна. Найдварт байдлын шинжилгээгээр үнэлэгчдийн хоорондын үнэлгээ найдвартай гарсан нь судалгааны үр дүнгийн үндэслэлтэй, баталгаатай байгааг харуулж байна. Энэхүү судалгаа нь олон улсын хөтөлбөр болон цөм хөтөлбөрийн агуулгын тэнцвэрийг тодорхойлж, цаашдын хөтөлбөрийн шинэчлэлд оновчтой чиглэл, бодлогын үндэслэл болох ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: Кембрижийн хөтөлбөр, цөм хөтөлбөр, content mapping

Газар зүйн мэдээллийн системийн өгөгдөлд суурилан боловсролын хүртээмжийг сайжруулах боломж

Х.Бямбажав¹, М.Мэнд-Амар²

¹МУБИС, byambajav.kh@msue.edu.mn

²МУИС, mendamarm@num.edu.mn

Abstract: The Mongolian education system faces increasing pressure from demographic shifts and urban migration, resulting in uneven school accessibility and capacity constraints. According to national statistics for the 2023–2024 academic year, 871 general education schools are operating across the country, with 498 located in the capital city and 373 in rural areas, accommodating a total of 771,722 students. Of these, 287,226 students attend schools outside their designated catchment zones, and 2,418 students in 64 classrooms (primarily in public schools) are compelled to study in a third shift due to overcrowding. These circumstances contribute to significant educational inequities, increased travel distances for students, and potential academic delays. This study aims to identify optimal strategies for improving school accessibility and spatial equity through data-driven planning. Utilizing geographic data from the 2022–2023 Education Sector Information System, covering 815 schools and 410,458 students, a spatial optimization model was developed. By calculating distances between students' residences and schools using geocoordinate data, the model evaluates scenarios such as reassigning students to closer schools, expanding current facilities, or constructing new schools in underserved areas. The analysis was conducted using Python algorithms and visualized with Tableau, offering practical recommendations for improving educational infrastructure planning and student welfare at the national level.

Keywords: School zoning, education accessibility, spatial optimization, school infrastructure planning, geospatial data analysis.

Шинэ эгэл арга зүй: Монгол хүний хөгжлийг дэмжих цогц арга ухаан

Д.Улам-Оргих¹, Д.Баясгалан², Д.Батцэцэг¹

¹МУИС, ulamorgikh@num.edu.mn ²Говь-Алтай, 1-р сургууль

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монголын боловсролын чанар, шинэчлэлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлж буй «Шинэ эгэл арга зүй» хэмээх инновацлаг арга зүйг танилцуулж байна. Уг арга зүй нь монгол уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны гүн үндэс суурьтай бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны ололт, технологийн дэвшилтэй хослуулан хөгжүүлж буй өвөрмөц онцлогтой. «Шинэ эгэл арга зүй» нь эгэл үйлд төвлөрөх, сэтгэл тогтоох, зөв үйл хийх ухааныг эзэмшүүлэхэд чиглэдэг бөгөөд бүх түвшний боловсролын тогтолцоонд нийцэхүйц, хялбар ойлгомжтой хэрнээ гүн гүнзгий философитой. 2020 оноос БЕГ-ийн дэмжлэгтэйгээр алслагдсан сургуулиудад туршин хөгжүүлж буй энэхүү арга зүй нь Говь-Алтай аймагт бага боловсролын математикийн хичээлээр хэрэгжсэн туршилтаар сурагчдын сурлагын амжилт, мэдлэгээ хэрэглэх чадварыг мэдэгдэхүйц дээшлүүлсэн эерэг үр дүнг үзүүлсэн. «Шинэ эгэл арга зүй» нь зөвхөн сурагчдыг хөгжүүлэх бус, багшийн мэргэжлийн өсөлтөд ч чухал нөлөө үзүүлж, Монголын боловсролын салбарт үнэ цэнэтэй инноваци болохыг харуулж байна.

Түлхүүр үгс: Эгэл бүхэл арга зүй, Монгол арга ухаан, Хүмүүн хөгжил, Төрөлх хэл, Инвариант, Бүхэл арга зүй, Боловсролын шинэчлэл, сэтгэл тогтоох, боловсролын инноваци

ЕБС-ийн багш нарын ажил-амьдралын тэнцвэрийн судалгаа

П.Баасансүрэн baasansuren@shinemongol.edu.mn

Д.Хишигжаргал khishigjargal@shinemongol.edu.mn

Э.Эрдэнэтуяа erdenetuya.e@shinemongol.edu.mn

П.Шинэтуяа shinetuya@shinemongol.edu.mn

Д.Отгонтуяа, d.otgontuya@shinemongol.edu.mn

Хураангуй: Ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангах нь багш нарын сайн сайхан байдалд чухал ач холбогдолтой. Багш нар ажлын ачаалал ихтэй байх үед стресс, ядрах, харилцаа хандлага, эрүүл мэндэд нь сөрөг нөлөө үзүүлдэг. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, өрсөлдөөн, ажлын байрны соёл зэргээс шалтгаалан ажилчдад ажил, гэр бүлийн амьдралаа тэнцвэржүүлэх нь төвөгтэй байгааг олон судалгаанаас харж болно. Багшийн ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангах нь багшийн ажлын гүйцэтгэл, сэтгэл ханамж, тогтвортой ажиллахад чухал нөлөөлдөг.

Монгол улсын төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 227 багш хамрагдсан судалгаанаас, багшийн ажил-амьдралын тэнцвэрт байдалд сургуулийн удирдлагын ур чадвар хангалтгүй, төлөвлөлт оновчгүй, удирдлагын харилцаа, хандлага сөрөг, цалин, урамшуулал хангалтгүй зэрэг үзүүлэлтүүд нөлөөлдөг болох нь нотлогдсон.

ЕБС-ийн багш нарын ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангахын тулд сургуулийн удирдлага буюу захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан төлөвлөлт, зохион байгуулалтаа сайжруулах, удирдлагын ур чадвараа нэмэгдүүлэх, багш нарын санал хүсэлт, шийдлийг ажил сайжруулах чухал арга хэрэгсэл хэмээн ухамсарлан авч үзэж шийдвэр гаргалтдаа ашиглах нь багшийг ажлын байрандаа сэтгэл хангалуун, тогтвортой ажиллахад нөлөөлнө.

Түлхүүр үгс: Багшийн ажил-амьдралын тэнцвэр, ажлын ачаалал, оновчгүй төлөвлөлт

Үйл ажиллагааны интеграцид суурилсан бие даалтаар ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгосон туршлага, үр дүн (Англи хэл, нийгэм судлалын хичээлийн жишээн дээр)

У.Цэвээндулам¹, Б.Баярмаа²

¹Шинэ Монгол Харүмафүжи сургууль, u.tseveendulam@shmhf.edu.mn,

²Шинэ Монгол Харүмафүжи сургууль, b.bayarmaa@shmhf.edu.mn

Хураангуй: Энэхүү судалгаа нь ахлах ангийн сурагчдад англи хэл, нийгмийн ухааны интеграцчилсан бие даасан даалтаар дамжуулан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох нь үр дүнтэй байдлыг судалсан болно. Тоон арга (асуулга, SPSS ашиглан статистик дүн шинжилгээ) болон чанарын аргуудыг (фокус бүлгийн ярилцлага, агуулгын дүн шинжилгээ, үйлийн судалгаа) зэрэг аргуудыг ашигласан. Судалгааг Шинэ Монгол Харүмафүжи сургуулийн 5-р үеийн 130 сурагчийн дунд явуулсан байна. Судалгааны үр дүн хэд хэдэн гол санааг онцолж байна. Нэгдүгээрт, ажил мэргэжлийн чиг баримжааг хичээлүүдээр нэгтгэх нь сурагчдын шүүмжлэлтэй сэтгэлгээ, судалгааны чадвар, төлөвлөх чадварыг зэргийг дээшлүүлж байна. CV бичих, төлөвлөх, дадлага хийх зэрэг ажил мэргэжилтэй холбоотой үйл ажиллагаанууд практик хэрэглээнд сурагчдын мэргэжил сонголтод хамгийн их нөлөөлсөн. Түүнчлэн энэхүү судалгаа нь сургалтын хөтөлбөрийг сайжруулах үндэс суурь болж, илүү уян хатан, сурагч төвтэй хандлагыг санал болгож байна. Сурагчдын 95% нь мэргэжлээ сонгосон бөгөөд гадаадад суралцах сонирхолтой 100 оюутны 96 нь олон улсын шалгалт өгч, зарим нь амжилттай элссэн байна. Цаашилбал, интеграцчилсан бие даалтууд нь урам зориг, өөртөө итгэх итгэл,

зорилгод чиглэсэн суралцахуйд чиглүүлсэн. Сурагчид зарим бие даалтуудыг хийх явцад бага зэргийг дарамт мэдэрсэн ч эцсийн дүнд их дээд сургуульд элсэн ороход бэлтгэхэд түлхэц болж байгаа гэдгийг дурьдсан. Энэхүү судалгаа нь интеграцчилсан бие даалт ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход үр дүнтэй арга гэдгийг харуулж, боловсролын хөтөлбөр шинэчлэлд, практикт хувь нэмрээ оруулж байна.

Түлхүүр үг: ахлах ангийн сурагч, мэргэжлийн чиг баримжаа, интеграцчилсан бие даалт

ЕБС-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээний үр дүнгээс

М.Хүрэлтогоо¹, Г.Бүрэнжаргал²

^{1,2}Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, khureltogoo@mier.mn
burenjargal@mier.mn

Хураангуй: Дэлхий дахинд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан гамшигт үзэгдлийн хамрах хүрээ нэмэгдэж, давтамж нь ихсэн, эрчим, үргэлжлэх хугацаа нь улам бүр нэмэгдэж байна. Манай улсад нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг 10 гаруй төрлийн цаг агаарын үзэгдэл болдог бөгөөд нийгэм, эдийн засгийн эрсдэлээр нь эрэмбэлбэл ган зуд, ой хээрийн түймэр, шороон болон цасан шуурга, уруйн үер, аадар бороо, мөндөр зэрэг нь голлох гамшигт үзэгдлийн тоонд багтдаг.

Манай улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 63 удаа тохиолддог байсан бол сүүлийн 10 жилд дунджаар 99 удаа болж нэмэгдсэн байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан гамшигт үзэгдлийн хамрах хүрээ нэмэгдэж, давтамж нь ихсэн, эрчим, үргэлжлэх хугацаа нь улам бүр нэмэгдэж байгаа үед ерөнхий боловсролын сургуулиуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрхэн боловсруулж, гамшиг онцгой нөхцөл байдлын үед бэлэн байдлыг хэр хангаж байгааг судлах нь зайлшгүй чухал байна. Энэ судалгаанд ерөнхий боловсролын сургуулиуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг загварын дагуу боловсруулж буй эсэх, тусгаж буй арга хэмжээ нь гамшиг онцгой нөхцөл байдлын үеийн бэлэн байдлыг хэр хангаж байгааг тодруулахыг зорьсон болно. Шинжилгээний дүнгээс харахад судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиуд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар"-ын дагуу боловсруулаагүй байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд ерөнхий, тодорхой, хэмжигдэхүйц байхаар тусгагдаагүй байна. Иймээс төсөв санхүүг хуульд заасны дагуу тусгаж, орон нутгийн засаг захиргаа, онцгой байдлын газрын оролцоо, мэргэжлийн дэмжлэгтэй, бодит амьдралд хэрэгжихүйц арга хэмжээг тусган боловсруулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Ерөнхий боловсролын сургууль, төлөвлөгөө, гамшигт үзэгдэл, онцгой нөхцөл

Оюутны Суралцах Төлөв Ба Хичээл Сонголтын Хамаарал

А.Амгалан¹, Я.Мөнхсайхан², Д.Цолмонтуйа³, У.Алимаа³

¹МУБИС, БТС, a.amgalan9296@gmail.com,

²МУБИС, МБУС, saikhnaa08ubi@gmail.com

³МУБИС, БТС, tsolmontuya@msue.edu.mn

³МУБИС, МБУС, alimaa.u@msue.edu.mn

Хураангуй: Өнөөгийн дээд боловсролын тогтолцоонд оюутнуудын суралцах төлөв, хандлага нь тэдний хичээл сонголтод шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Суралцах төлөв гэдэг нь тухайн оюутны сурах зорилго, хандлага, хүсэл эрмэлзэл, ирээдүйн зорилгоос хамааран тодорхойлогддог. Багш биеийн тамирын боловсролын хөтөлбөрийг судалж буй оюутнууд эхний дөрвөн улиралд ерөнхий суурь, багш мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлийг сонгосон байдал нь оюутны суралцах төлөвт нөлөөлж буй байдлыг судласан. Оюутны суралцах төлөвийг “суралцаж буй, хагас жилийн чөлөө, жилийн чөлөө, сургуулиас гарсан, тушаалаар гарсан, сураггүй, бусад” гэсэн ангиллаар авч үзсэн. Оюутны төлвийг эрэмбэлэн nonparametric test-ийн аргыг хэрэглэн шинжилгээ хийсэн. Ерөнхий суурийн хичээл сонголтын хорь гаруй хувь, багш мэргэжлийн суурийн гуч гаруй хувь мэргэжлийн хичээлийн сонголтын хорь орчим хувь нь сургуулиас гарч байна. Суралцаж буй төлөвт байгаа хичээлийн голч 2,27 ба дүн нь 80%-иас дээш байна. Багш мэргэжлийн тэтгэлэг нь оюутанд дэмжлэг болж байна. Тиймээс дээд боловсролын байгууллагууд оюутны суралцах төлөвийг дэмжих, чиглүүлэх бодлогыг боловсронгуй болгож, хичээл сонголтын үйл явцыг илүү ойлгомжтой, мэргэжлийн түвшинд удирдах шаардлагатай байна. Ийнхүү суралцах төлөв ба хичээл сонголтын хоорондын хамаарлыг зөв ойлгож, оновчтой удирдаж чадвал оюутны сургалтын чанар, сэтгэл ханамж, төгсөлтийн дараах хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ.

Түлхүүр үг: оюутны суралцах төлөв, хичээл сонголт,

ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ИЛТГЭЛҮҮД

Дидактик төвийн онол: үндэс, зарчим, хэрэглээ, ач холбогдол

Ц.Лувсандорж¹

¹МУБИС, Математик, Байгалийн Ухааны Сургуль, luvсандorj@msue.edu.mn

Хураангуй: Энэхүү илтгэлээр бид дидактик төвийн онолын үндсэн ойлголт, тодорхойлолт, үндсэн өгүүлбэр, ач холбогдлыг тодорхойлж, улмаар тэр нь дидактик онолуудын онол болохыг харуулахыг зорино.

Түлхүүр үг: дидактик төвийн онол

Integrating Pop Culture into English Language Teaching: Enhancing Engagement and Learning at the National University of Mongolia

Л.Энхжин¹, М.Баасанжав²

¹ МУИС, Шинжлэх ухааны сургууль, Гадаад хэлний төв, l.enkhjin@num.edu.mn

² МУИС, Шинжлэх ухааны сургууль, Гадаад хэлний төв, baasanjav@num.edu.mn

Abstract: This study explores the integration of pop culture into English language teaching (ELT) at the National University of Mongolia, aiming to enhance student engagement and learning outcomes. By incorporating contemporary media, music, film, and digital content relevant to students' interests, the research investigates how pop culture can serve as an effective pedagogical tool in the EFL (English as a Foreign Language) context. The findings suggest that using pop culture materials not only increases motivation and participation but also fosters a more relatable and dynamic learning environment. This approach supports the development of language skills while simultaneously promoting cultural awareness and critical thinking. The paper concludes with recommendations for educators seeking to implement pop culture elements in their curriculum to better connect with students and improve English language acquisition.

Оюутны стресс, бэрхшээлийг тэсвэрлэх, даван туулах, ангижрах чадварыг үнэлэх нь

Э.Эрдэнэтуяа¹, А.Энхтуяа², Ц.Нямсүрэн³, Д.Золжаргал⁴

^{1,2}МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, erdenetuya@num.edu.mn, enkhtuya@num.edu.mn

³МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, nyamsuren.ts@num.edu.mn

⁴МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, zoljargald@num.edu.mn

Хураангуй: Их сургуулийн оюутнууд амжилттай сурах, өрсөлдөхүйц чадвартай мэргэжилтэн болох, хурдацтайгаар өөрчлөгдөж байгаа нийгэмд дасан зохицох, ирээдүйн ажлаа төлөвлөх, гэр бүлийн өндөр хүлээлтэнд хүрэхээр эрмэлзэх зэрэг олон шаардлагын улмаас стресст илүүтэй өртөмтгий байдаг. Архаг стресс нь сэтгэцийн эрүүл мэнд, сурлагын амжилт, амьдралын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлдөг болохыг судалгаа харуулсаар байна (Beiter et al., 2015; Pascoe et al., 2020). Бид энэхүү судалгаагаараа оюутнуудын стрессийг тэсвэрлэх чадвар ямар түвшинд байгааг тодорхойлохыг зорьсон бөгөөд үүний тулд Стрессийг Даван Туулах Чадвар (BRS-6)-ыг тодорхойлох асуумжийг ашиглан их сургуулийн бакалаврын түвшний 417 оюутныг оролцуулан судалгаа авлаа. Стрессийг даван туулах чадварын асуумж нь Лайкертийн таван онооны сонголт бүхий зургаан асуулттай ба хувь хүний стресс, бэрхшээлийг тэсвэрлэх болон тэдгээрийг даван туулах, ангижрах чадварыг үнэлэх арга юм (Smith & Dalen, 2008). Энэхүү судалгааны үр дүнд судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын стрессийг даван туулах чадварын

дундаж утга 3.0 бөгөөд тэдний стрессийг тэсвэрлэх чадвар дунд зэрэг нь түүнчлэн хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна гэсэн үр дүн гарч байна. Мэргэжил болон насны хувьд ANOVA – шинжилгээний үр дүн ач холбогдолгүй гэсэн үр дүн гарсан байна. Ерөнхийд нь авч үзвэл оюутан залуусын бэрхшээлийг даван туулах чадвар дундаж бөгөөд хүйсийн хувьд ялгаатай, харин мэргэжил болон насны хувьд ялгаагүй хариу гарч байгаа нь аливаа саад бэрхшээлийг эрэгтэй, эмэгтэй оюутнууд өөр өөр байдлаар даван туулдаг болохыг харуулж байна. Оюутан суралцагчдын хувьд аливаа бэрхшээлийг даван туулах, шийдвэрлээд сургуулийн зүгээс анхаарал хандуулах,, сэтгэл зүйн тусламж үзүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Түлхүүр үг: оюутан, стрессийг тэсвэрлэх, даван туулах чадвар

Дэлхий судлалын дээд боловсрол ба төлөв

Л.Жамбажамц¹

¹МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, jambajamts@num.edu.mn

Хураангуй: Юнескогийн эрхлэн гаргасан ажил, мэргэжлийн ангилал дагуу байгалийн ухааны салбар дотор дэлхий судлалын дэд ангилалд өмнөх ангилалд өөр бүлгүүдээс зөөн ирсэн байгалийн ухааны олон мэргэжлүүд багтсан. Жишээлбэл цаг уур, ус судлал, уур амьсгал зэрэг нь өмнөх ангиллаар физик ба түүний салбар ангилалд байсан. Энэхүү юнескогийн ажил, мэргэжлийн ангилал дагуу дээд боловсролын шаталсан хөтөлбөрүүд шинэчлэгдэн батлагдаад нийлээдгүй хугацаа өнгөрчээ. Харамсалтай нь одоогоор дэлхий судлал ангилалын нарийн мэргэжлийн хөтөлбөрүүд элсэлтийн ба суралцах бүлэг үүсгэх шаардлагыг хангах элсэгч, суралцагчгүй байна. Ялангуяа элсэлтийн мэргэжил сонголтын хүсэлт, төсөөлөлийн судалгаануудад дэлхий судлалын мэргэжлүүдийн санал бараг тусгагдаагүй байна. Гэтэл азийн ба хойд америкийн орнуудад дээрх Юнескогийн ажил, мэргэжлийн ангилалаас бүүр өмнө дэлхий судлалын дунд ба дээд боловсролын дагнасан хөтөлбөрүүд нь уламжлалт сургалтын хэлбэрээ олсон байна. Манай орны хувьд дэлхий судлалын хөтөлбөр нь дунд боловсролын хөтөлбөрүүдэд шууд тусгагдаагүй газарзүй, физик, химийн хичээлүүд ба сурах бичгүүдэд тойм хэлбэрээр тусгагджээ. Энэхүү ялгаат зөрчлийн талаар өнөөгийн Монгол орны мэргэжилтнүүдийн санал ба шийдэх арга замыг эрэлхийлж АНР шинжилгээг дэлхий судлалын дунд ба дээд боловсролын мэргэжлийн багш нарын хүрээнд гүйцэтгэлээ. Шинжилгээний дүнгээр дэлхий судлалын дээд боловсролын элсэгчид ба суралцагсдын тоо бага байгааг дунд боловсролын хичээлүүдийн агуулгад дэлхий судлалын суурь ухагдахуунуудын хэрхэн тусгахтай холбоотой нь харагдлаа. Мөн дэлхий судлалын багшийн хөтөлбөрийг бусад орнуудын жишгээр байгуулах санал нийлээдгүй тусгагджээ.

Түлхүүр үг: юнеско ангилал, дэлхий судлал, АНР загвар, дунд боловсролын агуулга, дээд боловсролын хүртээмж.

ОЮУТАН СУДЛААЧИЙН ИЛТГЭЛҮҮД

Мэргэжил сонголтдо нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ

Б.Ундармаа¹, Ж.Анарзул², Н.Энхбаясгалан³, Ч.Даваасүрэн⁴

^{1,2,3}СЭЗИС-ийн оюутан

⁴СЭЗИС

Хураангуй: Монголын эцэг эхчүүдийн ерөнхий хандлага нь ямар ч мэргэжил сонгосон хүүхдийн цаашдын ирээдүй амжилттай мэтээр төсөөлөн, итгэдэг хандлага ойрын жилүүдэд ажиглагдах болсон. Үүнээс харахад цаашдын ирээдүйн мэргэжил, карьераа сонгох гэж буй хүүхдүүдэд эцэг эхчүүд хэрхэн нөлөө үзүүлдэг, цаашлаад сурлага болон бие даасан байдалд эцэг эхчүүд хэрхэн нөлөөлдөг талаарх судалгаа юм. Тиймээс энэхүү судалгаа СЭЗИС-ийн оюутнуудын мэргэжлээ сонгох болсон шалтгаан, цаашлаад голчид нөлөөлөх эцэг эхчүүдийн нөлөөг тодорхойлох зорилгоор олон улсад хийгдсэн зарим судалгаанд үндэслэн судалгаа хийлээ. Судалгааны хүрээнд оюутнуудын хувийн мэдээлэл, гэр бүлийн нөлөөллийн цар хүрээ, сурлагын сэтгэл ханамжтай байдал, тухайн оюутан хэр мэргэжил сонголтдоо итгэлтэй байх зэрэг орно. Эдгээр хүчин зүйлс тус бүрд оюутнуудын гэр бүлийн болон хувь хүний нөлөөлөх хүчин зүйлсийг илэрхийлэх асуумжуудыг олон улсын судалгаанаас жишээ авч боловсруулан, давтамжийн шинжилгээ, кластер шинжилгээ, корреляцийн шинжилгээ, хүчин зүйлийн хамаарлын шинжилгээний аргуудыг ашиглан үр дүнгүүдийг харуулав.

Түлхүүр үг: Мэргэжлээ бие даан сонгох чадвар, гэр бүлийн нөлөөлөл, академик сэтгэл ханамж

**Тэгш хамруулан сургах боловсролд сургуулийн удирдлагын оролцоо
(ЕБС-ийн жишээн дээр)**

Д.Номин¹

МУБИС, НХУС-ийн оюутан, davaadorjnomin21@gmail.com

Хураангуй: Тусгай хэрэгцээт сурагчдыг боловсролд тэгш хамруулах нь олон улсын болон Монгол Улсын боловсролын бодлогын нэг чухал чиглэл болж байна. Гэвч манай улсад 2023 оны байдлаар 20,548 хүүхэд тодорхой шалтгааны улмаас сургуульд хамрагдаж чадахгүй байгаа нь энэ тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл байгааг харуулж байна. Тэгш хамруулан сургах боловсролоор тэргүүлж буй улс орнуудын туршлагаас харах сургуулийн удирдлагын оролцоо өндөр байгаа тул уг сэдвийг хөндөж судалсан билээ. Судалгааны зорилго нь Монгол Улсад Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургахад удирдлагын үүрэг, оролцоо ямар түвшинд байгааг судалж, сайжруулах арга замыг санал болгоход оршино. Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд судалгааг сургуулийн удирдлага болон багш нараас ганцаарчилсан ярилцлага, ахлах ангийн сурагчдаас асуулгын аргаар хийж, орон нутаг, хотын төв, хотын зах болон хувийн сургуулиудын түвшинд харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнгээс товч дурдвал сургуулийн удирдлагууд тэгш хамруулах бодлогыг дэмждэг боловч бодит хэрэгжилт дутмаг, багш удирдлагын мэдлэг ойлголт нэгдмэл бус байгаа бөгөөд хотын зах болон орон нутгийн сургуулиудад сургалтын орчны хүртээмжийн асуудал нэн тэргүүнд тулгарч байна. Багш нар тусгай хэрэгцээт сурагчдад зориулсан сургалтын арга зүй дутмаг гэж үзэж байгаа бол эцэг эхчүүд, сурагчдын мэдлэг төсөөлөл, оролцоо хангалтгүй байгаа нь мөн нэг томоохон бэрхшээл болж байна. Тэгш хамруулан сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургуулийн удирдлагууд бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, багш нарын арга зүй, чадавхыг нэмэгдүүлэх тал дээр

анхаарч, сургалтын орчны хүртээмжийг сайжруулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Сурч боловсрох эрх, тэгш хамруулан сургах боловсрол, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, сургуулийн удирдлага, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ), сургуулийн дэмжлэгийн баг

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах буй 4-5 настай аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн нийгэмшихүйн чадварыг хөгжүүлэх нь

Л.Энхмаа¹, С.Батдулам²

¹МУБИС, БоСС-ийн магистрант, lenkhmaa44@gmail.com

² МУБИС, БоСС

Хураангуй: Бага насны хүүхдийн боловсролд манай улсаас гадна дэлхийн олон улс орнууд ихээхэн анхаарч алсын хараа, боловсролын зорилгодоо тусган хүний хөгжилдөө анхааран ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд улс орон бүр тэгш хүртээмжтэй боловсролыг чухалчлан ажиллаж байгаа хэдий ч боловсролын гадна үлдэж буй хүүхдүүд байсаар байгаа юм. 2019 онд Нью Йорк хотын судлаачид боловсролын хүртээмжийн тараалх судалгааг хийхэд СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болохыг илрүүлсэн байна (UNICEF, 2019). Монгол улсын хэмжээнд ч мөн адил боловсролын гадна үлдэж буй хэсэг бүлэг хүүхдүүдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа юм. 2024-2025 оны хичээлийн жил нийт 2150 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. СӨБ-д хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс хамгийн өндөр хамрагдалттай байгаа нь аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүд байна (Боловсрол, 2024). Үүнээс 4 болон 5 настай аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн хамрагдалт их байна. Тэдний ялгаатай хэрэгцээ, онцлогт тохируулан дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Түлхүүр үг: Сургуулийн өмнөх боловсрол, аутизмын хүрээний эмгэг, нийгэмшихүй, үнэлгээ, багш

Санхүүгийн мэргэжилтэнд өгөгдлийн шинжилгээний мэдлэг, чадварыг эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагыг өгөгдөл олборлолтын аргаар тодорхойлох нь

Б.Мишээл¹

¹СЭЗИС-ийн оюутан, b20fa1766@ufe.edu.mn

Хураангуй: Сүүлийн жилүүдэд дижитал шилжилт нь санхүүгийн салбарт хүчтэй нөлөө үзүүлж, санхүүгийн мэргэжилтнүүдээс улам бүр нарийн мэргэжлийн, дата төвтэй сэтгэлгээ, технологийн мэдлэг бүхий ур чадварыг шаардах болсон. Тус судалгааны үндсэн зорилго нь Монголын их дээд сургуулиудад хэрэгжиж буй бакалаврын санхүүгийн чиглэлийн хөтөлбөрүүд дижитал шилжилтийн орчинд шаардагдах мэдлэг, чадварыг хангалттай олгож чадаж байна уу гэдгийг хөдөлмөрийн зах зээл дээрх ажил олгогчдын тавьж буй шаардлагад тулгуурлан үнэлэхэд оршино. Судалгааны хүрээнд Zangia.mn цахим платформуос санхүүгийн чиглэлээр нийтлэгдсэн ажлын заруудыг вэб скрапинг аргаар цуглуулж, ажлын байрны нэршил, шаардлага, хэрэглэгдэх программ хангамж, ур чадварын ангилал зэргийг ялган авч, өгөгдөл олборлолтын техникүүд болох TF-IDF шинжилгээ, bigram сүлжээний анализ, давтамжийн тооцоо, чадварын heatmap зэргийг ашиглан боловсруулалт хийв. Уг судалгааны таамаглалаар, ажил олгогчдын тавьж буй ур чадварын шаардлагад өгөгдөл шинжилгээ, Excel программын гүнзгий хэрэглээ, Power BI, Python зэрэг аналитик хэрэгсэл, мөн судалгаанд суурилсан шийдвэр гаргах чадвар зонхилж байна. Харин их дээд сургуулиудад хэрэгжиж буй санхүүгийн

хөтөлбөрүүд санхүүгийн суурь мэдлэгүүдийг сайн олгож байгаа боловч дээрх орчин үеийн шаардлагатай мэдээллийн системийн чадварыг хангалттай олгож чадахгүй байх хандлагатай байна. Иймд Монголын их дээд сургуулиудын тус чиглэлийн хичээлүүдээр олгож буй мэдлэгийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэх, дата шинжилгээ, технологид суурилсан сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөрийн шинэчлэл хийх шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг: Дижитал шилжилт, өгөгдөл олборлолт, санхүүгийн боловсрол, ур чадварын эрэлт, хөдөлмөрийн зах зээл.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаа

Т.Ариунзаяа¹, Б.Жавзандулам²

¹МУБИС, СӨБС-ийн оюутан,

²МУБИС, СӨБС

Хураангуй: Боловсролын ерөнхий хуулийн 10.1.9-д заасны дагуу “хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах” эрхтэй хэмээн заасан байдаг. Цэцэрлэгийн ердийн бүлэгт тэгш хамруулах зарчмын үүднээс хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хэмээн оношлогдсон хүүхдийг хөгжүүлэх сургалт үйл ажиллагааг ганцаарчилсан сургалтаар зохион байгуулж байна. Энэхүү судалгаагаар тавьсан тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй багшийн ганцаарчилсан сургалтын хэрэгжилтийг судлах, судалгааны үр дүнд суурилсан санал зөвлөмж боловсруулах зорилгын хүрээнд ганцаарчилсан сургалттай холбогдох бичиг баримтад шинжилгээ хийж, 12 цэцэрлэгийн бүлгийн багшаас ярилцлага авч, 25 хүүхдээс 6 хүүхдийг ажигласан. Хүүхдийн хөгжлийн онцлогоос хамааран хэрэгжилт харилцан адилгүй бөгөөд төлөвлөсөн төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэхэд цаг хугацаа, орон зай тун бага байдаг бөгөөд багш, эцэг эх, боловсролын байгууллага, холбогдох байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон дэмжлэгийг тасралтгүй үзүүлэх нь нэн чухал байна.

Гэрийн даалгаврын талаарх тулгамдсан асуудал, шийдэл

Б.Саранчулуун¹, Б.Энхтунгалаг², П.Одончимэг³

^{1,2,3}Орхон, 4 дүгээр сургууль

Хураангуй: Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын анхаарал татаж байгаа нэг асуудал бол суралцагчдын бие даасан ажил. Бие даасан ажил гэдэгт суралцагч багшийн шууд оролцоогүй боловч багшийн даалгавраар хичээлээс гадуурх эсвэл гэрийн ажлыг ганцаарчлан буюу бүлгээр хийж гүйцэтгэхийг хэлнэ. Бие даасан ажил нь хичээлийг зөв зохион байгуулсны үр дүн бөгөөд суралцагчдын чөлөөт цагаар хичээл сургалтаар олж авсан мэдлэг чадвараа бие даан баяжуулах, гүнзгийрүүлэх, үргэлжлүүлэх үйл явц юм. (Бадмаев Б.Ц. Методика преподавания психологии. М., 2001, С. 239) Бие даах үйл явцын нэг хэлбэр гэрийн даалгаврыг шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх үүднээс бүтээлч шинж чанартай болгох, сурагчдын сонирхлыг төрүүлэхийн тулд гэрийн даалгаврын агуулгад ажиглалт, энгийн туршилт хийх, асуудлыг хэд хэдэн аргаар шийдвэрлэх, унших боломжтой шинжлэх ухаан болон уран зохиол, бие даасан дүгнэлт, дүгнэлт бэлтгэх” гэжээ. (Сурган хүмүүжүүлэх ухаан.1999,х.205) Олон улын түвшинд Германы судлаач Элке Вилдгэрийн даалгаврын талаар хэлэхдээ “Та арын фононд л байхыг хичээ. Хийж байгаа зүйлийг нь бүү тасалдуул. Хэрэв хүүхэд тань туслалцаа хүсвэл харин дэмжлэг үзүүлэхэд бэлэн бай. Тэдэнд нэг талаас сэтгэл санааны дэмжлэг, нөгөө талаас тодорхой аргачлал хэрэгтэй” гэжээ. Харин Хайнц Петер Майдингер “Гэрийн даалгаврыг хүүхэд

төгс төгөлдөр хийх албагүй. Харин ч түүний эсрэгээр. Хэрэв гэрийн даалгавар хийхдээ хүүхэд алдсан, тэр нь харагдаж байвал тухайн хүүхдэд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар багшид чухал мэдээлэл өгнө" гэжээ. Нийгэмд боловсролын үйл явц, тэр дундаа ээлжит хичээлийн чухал хэсэг болох гэрийн даалгавраас үүдсэн сурган хүмүүжүүлэх харилцааны асуудал, түүнийг дагасан сөрөг хандлага маш их байгаа учир түүнийг шийдвэрлэх асуудал боловсролын өмнө тулгараад байгаа. Асуудлыг шийдвэрлэхийн тулд 2014 оноос Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн бага боловсролын багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн дунд судалгаа явуулж, тулгамдсан асуудлыг шийдэхээр зорьсон. Судалгааны үр дүнд тулгуурлан, гэрийн даалгаврын ачаалал, тавил, хэлбэр, хийх хугацаа, ялгаатай түвшинд тохирсон даалгавар боловсруулах, даалгаврын сан бий болгох үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулснаар хүүхдийн бие даан бүтээлчээр суралцах чадвар, сурлагын амжилтыг бодитой үнэлэхэд ахиц гарч, багш асран хамгаалагч, суралцагчдын харилцаанд эерэг хандлага бий болсон тул "Жаргалтай-бүтээлч гэрийн даалгавар-1,2" хөтөлбөрөөр үргэлжлүүлэн, илүү үр дүнд хүрч, хөгжих арга зүйг судалсаар байна.

Түлхүүр үг: Конструктив, гэрийн даалгавар, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, ёс зүй, харилцаа

Сурагчдын химийн бодлого бодох чадварыг сайжруулах арга зүйн нэгэн хувилбар

Г. Дөлгөөн¹, Б. Норовсүрэн²

¹МУБИС, МБУС-ийн магистрант, ganhuudulguun11@gmail.com

²МУБИС, МБУС, norovoo@msue.edu.mn

Хураангуй: Энэхүү судалгааны ажил нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын химийн бодлого бодох чадварыг сайжруулах зорилгоор алхамчилсан ба давтамжтай сургалтын арга зүйг боловсруулан хэрэглэсэнээр, бодлогын гүнзгий ойлголт, бие даан шийдвэрлэх чадвар хэрхэн нэмэгдэж байгааг тогтоохыг зорьсон. Судалгаанд "Химийн энерги" сэдвийн хүрээний дөрвөн төрлийн бодлогыг сонгон авч, бодох алхамчилсан загвар боловсруулан тодорхой давталттайгаар зааж туршсан. Үр дүнд нь сурагчдын зөв гүйцэтгэлийн хувь мэдэгдэхүйц өссөн төдийгүй 30 хоногийн дараах шалгалтаар ч мэдлэгийн тогтвортой байдал хадгалагдсан байна. Судалгааны арга зүйд ажиглалт, шалгалтын гүйцэтгэл, SPSS программын статистик боловсруулалт ашигласан. Энэхүү судалгаа нь сурагчийн танин мэдэхүйн ачаалал, стрессийг зохистой түвшинд удирдан, бодлого бодох чадварыг шат дараалсан арга зүйгээр дэмжих боломжийг харуулж, химийн боловсролд сургалтын шинэ хандлагыг санал болгож байна.

Түлхүүр үг: алхамчилсан сургалт, давтамжтай бодолт, химийн бодлого бодох чадвар

Судалгааны ажлыг гүйцэтгэх мэдлэг чадварыг баримт бичгийн шинжилгээнд тулгуурлан тодорхойлох нь (МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн оюутнуудын судалгааны ажлын жишээн дээр)

Б.Батцэцэг¹

¹Боловсрол судлалын магистрант, batzorigseseg@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгаагаар МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн оюутнуудын судалгааны ажил бичих мэдлэг, чадварыг баримт бичгийн шинжилгээний аргаар тодорхойлохыг зорилоо. Судалгааны ажлын үндсэн бүтэц болох удиртгал, арга зүй, үр дүн, дүгнэлт зэрэг хэсгүүдийг 3 өөр оюутны илтгэлийн жишээн дээр харьцуулан судалж, тэдгээрийн судалгааны бүтэц эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэцтэй хэрхэн уялдаж байгааг, логик дарааллыг ямар хэлбэрээр хийж гүйцэтгэж байгааг задлан шинжлэхийг

хичээлээ. Үр дүнд нь оюутнууд судалгааны бүтэц, арга зүй болон судалгааны аргын ялгаа, дэс дараалал, үр дүнг боловсруулах, дүгнэх чадварт тодорхой зөрүүтэй байгааг илрүүлэв. Судалгааны үр дүн нь цаашид оюутнуудад зориулсан судалгааны арга зүйг хичээл сургалтын агуулгаар системтэйгээр эзэмшүүлэх шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: Судалгаа, мэдлэг чадвар, оюутан

ТЭМДЭГЛЭЛ